

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

ГААЛИЙН АВТОМАТЖУУЛСАН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ӨРГӨТГӨЛИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ, СУУРИЛУУЛАХ

Захиалагч: Сангийн яам

Улс: Монгол

Төслийн дугаар ба нэр: L3313-MON: Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл

Тендерийн дугаар: G3

Олгосон огноо: 2025 оны 01-р сарын 17-ны өдөр

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ – ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ГОРИМ

Нэгдүгээр бүлэг. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа (ТООЗ)

Энэ бүлэг нь тендер бэлтгэхэд шаардлагатай бүх мэдээллийг тендерт оролцогчдод өгөх зорилготой. Тендер ирүүлэх, нээх, үнэлэх болон гэрээ байгуулах эрх олгохтой холбоотой мэдээллийг агуулна. Захиалагч энэ бүлгийн бүх зүйл заалтыг өөрчлөхгүйгээр ашиглана.

Хоёрдугаар бүлэг. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (ТШӨХ)

Энэ бүлэгт тухайн худалдан авах ажиллагаанд тохирсон онцлог заалтуудыг тусгах бөгөөд эдгээр нь Нэгдүгээр бүлгийн холбогдох зүйл заалтыг тодруулсан нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ.

Гуравдугаар бүлэг. Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт

Энэ бүлэг нь захиалагчаас тендерийг үнэлэх, мөн “хамгийн сайн” үнэлэгдэх тендерт оролцогчийг сонгоход ашиглах шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлно.

Дөрөвдүгээр бүлэг. Тендер шалгаруулалтын маягт

Энэ бүлэгт тендер ирүүлэх маягт, үнийн хуваарийн хүснэгт, тендерийн баталгаа ба үйлдвэрлэгчийн зөвшөөрөл зэрэг тендерт оролцогчоос тендерийн хамт бөглөж ирүүлэх шаардлагатай маягтууд багтана.

Тавдугаар бүлэг. Эрх бүхий орнууд

Энэ бүлэгт АХБ-ны эрх бүхий орнуудын жагсаалт багтана.

ХОЁРДУГААР ХЭСЭГ – БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Зургаадугаар бүлэг. Нийлүүлэх хуваарь

Энэ бүлэгт худалдан авах бараа болон холбогдох үйлчилгээний жагсаалт, тэдгээрийг захиалагчид хүргэх хуваарь, тэдгээр бараа, дагалдах үйлчилгээг тайлбарлан дүрсэлсэн техникийн тодорхойлолт болон зураг зэрэг мэдээлэл багтана.

ГУРАВДУГААР ХЭСЭГ – ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ БА МАЯГТ

Долдугаар бүлэг. Гэрээний ерөнхий нөхцөл (ГЕН)

Энэ бүлэг нь захиалагчаас бараа ба холбогдох үйлчилгээг худалдан авах гэрээний харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. ГЕН-ийн заалтуудын үг, үсэг, агуулгыг өөрчилж үл болно.

Наймдугаар бүлэг. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)

Энэ бүлэгт тухайн худалдан авах барааны онцлогт тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулсан нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ.

Есдүгээр бүлэг. Гэрээний маягт

Энэ бүлэгт гэрээний маягт болон захиалагч шаардсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгогдсоны дараа шалгарсан тендерт оролцогчийн бөглөж ирүүлэх гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааны маягтууд багтана.

Хавсралт: Тендерийн урилга

Тендерийн урилгын маягтыг энэхүү Тендерийн жишиг баримт бичигт жишээ болгон хавсаргав.

Жич: Энэхүү тендерийн жишиг баримт бичгийн хэсэг, бүлгийн оноосон нэр, гарчиг нь уг баримт бичгийг ойлгоход хялбар дөхөм болгох зорилгоор хэрэглэсэн бөгөөд ямар нэгэн хэм хэмжээ илэрхийлэхгүй болохыг анхаарна уу.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ– ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ГОРИМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааг бөглөх санамж

Захиалагчийн шаардлагад нийцсэн тендер бэлтгэхтэй холбоотойгоор тендерт оролцогчдод шаардлагатай бүрэн мэдээллийг энэ бүлэгт тусгана. Түүнчлэн тендер хүлээн авах, нээх, үнэлэх, “хамгийн сайн” тендерийг шалгаруулах болон гэрээ байгуулах эрх олгох үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг багтаана. Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ захиалагч ТООЗ-г чанд мөрдөнө. ТООЗ нь жишиг нөхцөл, заалтуудыг агуулах бөгөөд түүнийг хэрэглэхдээ ямар нэгэн өөрчлөлт, нэмэлт болон хасалт хийж үл болно. Хэрэв тухайн тендерийн үйл ажиллагаатай холбоотой тусгайлсан нөхцөл, заалтыг дурдах шаардлагатай бол эдгээр онцлог заалтыг зөвхөн ТШӨХ-д тусгана.

Нийлүүлэгчийн гэрээний үүрэг, гэрээний төлбөр, талуудын эрх үүрэг, хүлээх эрсдэлтэй холбогдсон нөхцлийг энэ бүлэгт бус, харин Долдугаар бүлэг (Гэрээний ерөнхий нөхцөл) болон Наймдугаар бүлэг (Гэрээний тусгай нөхцөл)-г тус тус заана.

ТООЗ нь тендерийн баримт бичгийн бүрэлдэхүүн болох ба харин гэрээний хэсэг болохгүй.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

АГУУЛГА

- А. Ерөнхий зүйл**
1. Тендерийн цар хүрээ
 2. Санхүүжилтийн эх үүсвэр
 3. Залилан ба авлигын үйлдэл
 4. Эрх бүхий тендерт оролцогч
 5. Эрх бүхий бараа ба холбогдох үйлчилгээ
 6. Түншлэл
- Б. Тендерийн баримт бичиг**
7. Тендерийн баримт бичгийн агуулга
 8. Тендерийн баримт бичгийг тодруулах
 9. Тендерийн баримт бичгийг өөрчлөх
- В. Тендер бэлтгэх**
10. Тендер шалгаруулалтад оролцох зардал
 11. Тендерийн хэл
 12. Тендерийн иж бүрдэл
 13. Тендер ирүүлэх маягт ба үнийн хуваарь
 14. Хувилбарт тендер
 15. Тендерийн үнэ ба хөнгөлөлт
 16. Тендерийн ба төлбөрийн валют
 17. Тендерт оролцогчийн эрх бүхий эсэхийг нотлох баримт
 18. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт
 19. Бараа ба холбогдох үйлчилгээ нь эрх бүхий эсэхийг нотлох баримт
 20. Бараа ба холбогдох үйлчилгээ нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэж буй эсэхийг нотлох баримт
 21. Тендер хүчинтэй байх хугацаа
 22. Тендерийн баталгаа
 23. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах
- Г. Тендер ирүүлэх**
24. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх
 25. Тендер хүлээн авах эцсийн хугацаа
 26. Хугацаа хоцорсон тендер
 27. Тендерийг буцааж авах, солих, өөрчлөх
- Д. Тендерийг нээх, үнэлэх**
28. Тендерийг нээх
 29. Нууцлал
 30. Тендерийг тодруулах
 31. Зөрүү, болзолт нөхцөл ба орхигдуулсан зүйл
 32. Тендерийг хянан үзэж, шаардлагад нийцэж буй эсэхийг тогтоох
 33. Жижиг зөрүү
 34. Арифметик алдааг залруулах
 35. Нэг валютад хөрвүүлэх
 36. Давуу эрхийн зөрүү
 37. Тендерийг үнэлэх, харьцуулах
 38. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах
 39. Аливаа тендерийг хүлээн зөвшөөрөх, мөн бүх эсхүл аливаа тендерээс татгалзах захиалагчийн эрх
- Е. Гэрээ байгуулах эрх олгох**
40. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур
 41. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
 42. Эрх олгох үед тоо хэмжээг өөрчлөх захиалагчийн эрх
 43. Гэрээнд гарын үсэг зурах
 44. Гүйцэтгэлийн баталгаа

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- | | | |
|-------------------------------------|------|--|
| 1. Тендерийн цар хүрээ | 1.1. | Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (ТШӨХ)-д тодорхойлсон захиалагч нь ТШӨХ-д заасан бараа, материал болон тоног төхөөрөмж (цаашид “бараа” гэх) нийлүүлэхээр энэхүү тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. |
| | 1.2. | Тендер шалгаруулалт нь ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд нэг багцтай байна. Хэрэв багцалсан бол тендерт оролцогч нэг, эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлэх эрхтэй. |
| | 1.3. | Энэхүү тендерийн баримт бичигт:

(а) “бичгээр” гэдэг нь хүлээн авсан гэдгээ нотолж бичгээр харилцахыг хэлнэ;

(б) тухайн утга агуулгаас нь хамааран ганц тоог олон тоон дээр ойлгох, мөн эсрэгээр олон тоог ганц тоон дээр ойлгоно;

(в) “хоног” гэж хуанлийн өдрийг хэлнэ. |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр | 2.1. | ТШӨХ-д дурдсан Зээлдэгч эсхүл Хүлээн авагч (цаашид “Зээлдэгч” гэх) нь ТШӨХ-д нэрлэсэн төслийн хүрээнд ТШӨХ-д заасан санхүүжилтийн эх үүсвэрээс Азийн Хөгжлийн Банкнаас (цаашид “АХБ” гэх) санхүүжилт (цаашид “санхүүжилт” гэх) хүлээн авна. |
| 3. Залилан ба авлигын үйлдэл | 3.1. | Төрийн албан хаагч, тендерт оролцогч болон гэрээлэгч нь худалдан авах ажиллагаанд оролцон гэрээг хэрэгжүүлэхдээ ёс зүйн өндөр хэм хэмжээг дагаж мөрдөх ёстой. |
| | 3.2. | Гэрээнд өрсөлдөх явцад Авлигын эсрэг хууль, Эрүүгийн хууль, Өрсөлдөөний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан авлига, залилан мэхлэх, үгсэн хуйвалдах, айлган сүрдүүлэх үйлдэлд аль нэг оролцогч шууд өөрөө эсвэл төлөөлөгчөөрөө дамжуулан холбогдсон тухай нотолгоо баримт байгаа бол төрийн албан хаагч, тендерт оролцогч болон гэрээлэгч нь холбогдох албан тушаалтан, хууль, хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй. |
| | 3.3. | АХБ-ны авлигын эсрэг бодлого нь зээлдэгч (түүний дотор АХБ-ны санхүүжилттэй үйл ажиллагааны үр шим хүртэгч) төдийгүй АХБ-ны санхүүжилттэй гэрээний тендерт оролцогч, нийлүүлэгчээс худалдан авах ажиллагаа болон гэрээний хэрэгжилтийн явцад ёс зүйн өндөр хэм хэмжээг баримтлахыг шаарддаг. Энэ бодлогыг мөрдлөг болгох үүднээс АХБ нь:

(а) Энэхүү заалтын хүрээнд доор дурдсан нэр томъёог дараах байдлаар тодорхойлно:

(1) “авлигын үйлдэл” гэдэг нь бусдын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд аливаа үнэ бүхий зүйлийг шууд буюу шууд бусаар санал болгох, өгөх, авах, эсхүл хүсэхийг;

(2) “залилан мэхлэх үйлдэл” гэдэг нь санхүүгийн болон бусад үр шим хүртэх эсхүл үүрэг хариуцлагаас мултрах зорилгоор бусдыг санаатайгаар буюу санамсаргүйгээр төөрөгдүүлэх, эсхүл |

төөрөгдүүлэхийг оролдсон аливаа үйлдэл хийх, баримтыг орхигдуулах, худал мэдүүлэхийг;

(3) “дарамт шахалт үзүүлэх үйлдэл” гэдэг нь аливаа талын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд аливаа талд буюу түүний өмч хөрөнгөнд шууд эсхүл шууд бусаар хохирол учруулах, эсхүл хохирол учруулахаар заналхийлэхийг;

(4) “үгсэн хуйвалдах үйлдэл” гэдэг нь хоёр буюу түүнээс дээш этгээд зүй бус зорилгод хүрэх, түүний дотор бусдын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх зорилгоор хоорондоо тохиролцоо хийхийг;

(5) “шударга бус байдлын зөрчил” гэдэг нь АХБ-ны Шударга байдлын зарчим ба журамд тодорхойлсноор, авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, үгсэн хуйвалдах, албан тушаалаа урвуулан ашиглах болон ийм үйлдлийг таслан зогсооход саад учруулах замаар АХБ-ны Авлигын эсрэг бодлогыг зөрчихийг;

(6) “саад учруулах үйлдэл” гэдэг нь (а) АХБ-наас хийж буй хяналт шалгалтын явцад нотолгоо болох баримт материалыг санаатайгаар устгах, хуурамч баримт үйлдэх, баримт материалыг өөрчлөх буюу нуун дарагдуулах; (б) АХБ-ны хяналт шалгалтын явцад саад учруулахын тулд хяналт шалгалт хийж буй хүмүүст худал мэдүүлэг өгөх; (в) АХБ-ны Авлигатай тэмцэх, шударга байдлын газраас хийж буй хяналт шалгалттай холбогдуулан гаргаж өгөхийг хүссэн мэдээлэл, баримт бичиг, данс бүртгэлийг гаргаж өгөхгүй байх; (г) хяналт шалгалттай холбоотой асуудлаар мэдүүлэг өгүүлэхгүй байх эсхүл мэдүүлэг өгөхөд нь саад учруулахын тулд аливаа этгээдэд заналхийлэх, дарамт шахалт үзүүлэх, түүнийг айлган сүрдүүлэх; (д) АХБ-тай байгуулсан гэрээний дагуу аудит хийх буюу мэдээлэл олж авахад санаатайгаар саад учруулахыг тус тус хэлнэ.

(б) Гэрээний эрх олгохоор санал болгосон тендерт оролцогч нь гэрээний эрхийн төлөө өрсөлдөх явцадаа шууд өөрөө эсхүл төлөөлөгчөөрөө дамжуулан авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, үгсэн хуйвалдах, саад учруулах эсхүл шударга бус байдлын бусад зөрчил гаргасан болох нь тогтоогдвол түүнд гэрээний эрх олгох саналаас татгалзана;

(в) АХБ-наас санхүүжилт авсан зээлдэгчийн эсхүл АХБ-ны санхүүжилтээс үр шим хүртэгчийн төлөөлөгч нь худалдан авах ажиллагаа, эсхүл гэрээг хэрэгжүүлэх явцад авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, үгсэн хуйвалдах, саад учруулах эсхүл шударга бус байдлын бусад зөрчил гаргахад оролцсон, мөн зээлдэгч энэ байдлыг засаж залруулах талаар АХБ-ны шаардлагад нийцэхүйц зохистой арга хэмжээг цаг тухайд нь аваагүй болох нь хэзээ нэгэн цагт тогтоогдвол тухайн гэрээнд хуваарилсан санхүүжилтийн хэсгийг цуцална;

(г) Хэрэв компани эсхүл хувь хүн шууд өөрөө эсхүл төлөөлөгчөөрөө дамжуулан авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, үгсэн хуйвалдах саад учруулах эсхүл шударга бус байдлын бусад зөрчил гаргасан болох нь тогтоогдвол, тодорхой эсхүл тодорхойгүй хугацаагаар АХБ-наас санхүүждэг, эсхүл АХБ-наас захиран зарцуулдаг арга хэмжээнд оролцох, эсхүл АХБ-наас санхүүждэг, эсхүл АХБ-наас захиран зарцуулдаг гэрээнээс санхүүгийн болон бусад хэлбэрээр үр шим хүртэх эрхгүй болохыг зарлах гэх мэтээр АХБ-ны Авлигын эсрэг бодлого, Шударга байдлын зарчим ба журам (тухай бүрдээ шинэчлэгдэж байдаг)-ын дагуу компани, хувь хүнд ямар ч үед хориг тавина;

(д) Тендерт оролцогч, нийлүүлэгчийн данс бүртгэл болон тендерийн санал ирүүлэх, гэрээний гүйцэтгэлтэй холбоотой баримт бичгийг хянан шалгах, АХБ-наас томилсон аудитын байгууллагаар тэдгээрийг хянуулахыг АХБ, түүний төлөөлөгчид зөвшөөрөхийг тендерт оролцогч, нийлүүлэгчээс хүссэн заалтыг АХБ-ны санхүүжилттэй тендерийн баримт бичиг болон гэрээнд тусгасан байхыг шаардах эрхтэй.

4. Эрх бүхий тендерт оролцогч

4.1 Тендерт оролцогч ба түншлэлийн гишүүд нь Тавдугаар бүлэг буюу Эрх бүхий орнуудын жагсаалтад заасны дагуу АХБ-ны эрх бүхий орны харьяат байна. Тендерт оролцогч нь тухайн орны иргэн, эсхүл тус улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулдаг бол тухайн улсын харьяат гэж үзнэ. Түүнчлэн, гэрээний тодорхой хэсэг болон барааны холбогдох үйлчилгээг гүйцэтгүүлэхээр тендерт оролцогчийн санал болгож буй нийлүүлэгч, туслан гүйцэтгэгчийн харьяаллыг тодорхойлоход энэхүү шалгуурыг мөн ашиглана.

4.2 Аль нэг талын ашиг сонирхол нь түүний албан үүрэг хариуцлага, гэрээний үүрэг, эсхүл хууль тогтоомжоор хүлээсэн үүрэгт нь харшлахаар бол түүнийг ашиг сонирхлын зөрчил бүхий гэж үзэх бөгөөд тэрхүү ашиг сонирхлын зөрчил нь АХБ-ны авлигын эсрэг бодлогын хүрээнд хориглосон үйл ажиллагааг явуулах үндэс суурь болж болзошгүй юм. АХБ-ны авлигын эсрэг бодлогын дагуу АХБ-ны зээлдэгч /АХБ-наас санхүүжигдэж буй үйл ажиллагаанаас үр шим хүртэгчид/ болон тендерт оролцогч, нийлүүлэгч нь ёс зүйн өндөр хэм хэмжээ сахих ёстой. Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын улмаас худалдан авах ажиллагаа шударга бус явагдахад хүрсэн нь тогтоогдвол АХБ төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зогсоох зэрэг зохих арга хэмжээг авна. Түүнчлэн, ашиг сонирхлын зөрчилтэй болох нь илэрсэн тендерт оролцогчдыг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана. Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд тендерт оролцогч нь энэхүү тендер шалгаруулалтад нэг ба түүнээс дээш этгээдтэй ашиг сонирхлын зөрчилтэй байна гэж үзэж болно. Үүнд:

(а) Хамтдаа гол хувьцаа эзэмшигчид нь болж байгаа бол;

(б) Аль нэг этгээдээс шууд ба шууд бус татаас авах эсхүл авч байсан бол;

(в) Тухайн тендер шалгаруулалтад хуулийн ёсны ижил төлөөлөгчтэй бол;

(г) Бусад тендерт оролцогчтой шууд, эсхүл гуравдагч этгээдээр дамжуулан холбоо харилцаатай бөгөөд энэ нь өөр этгээдийн тендерийн талаар мэдээлэл олж авах, эсхүл хөндлөнгөөс нөлөөлөх боломжийг бүрдүүлсэн, эсхүл энэхүү тендер шалгаруулалтын үйл явцтай холбоотой захиалагчийн шийдвэрт нөлөөлж болзошгүй бол;

(д) Тендерт оролцогч энэхүү тендер шалгаруулалтад нэгээс дээш тендерт оролцсон бол. Хэрэв тендерт оролцогч нэгээс дээш тендерт оролцвол, түүний оролцсон бүх тендер нь шаардлага хангаагүйд тооцогдоно. Гэхдээ, энэ нь ижил туслан гүйцэтгэгчийг тендерт оролцогчийн бус статустайгаар, нэгээс дээш тендерт оролцохыг хязгаарлахгүй.

(е) Тендерт оролцогч, түүний туслан гүйцэтгэгч нь худалдан авах бараа ба холбогдох үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд зөвлөхөөр оролцон ажиллаж байсан бол.

- 4.3 АХБ шууд өөрөө эсхүл Эрх хасах шийдвэрийг харилцан биелүүлэх хэлэлцээрт заасны дагуу АХБ-ны Авлигын эсрэг бодлогын (ТООЗ-ны 3-р заалтыг харах) хүрээнд тендерт оролцох эрхийг хязгаарласан бол тухайн компани нь АХБ-ны санхүүжилттэй эсхүл дэмжлэгтэй төслийн аливаа худалдан авах ажиллагаанд оролцох эрхгүй болно. Хориг жагсаалтанд орсон эсхүл бусад олон улсын байгууллагаас эрхээ хасуулсан компанийн тендерээс татгалзана.
- 4.4 Захиалагчийн улсын төрийн өмчит байгууллага нь (а) эрх зүй, санхүүгийн хувьд бие даасан, (б) аж ахуйн нэгжийн хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг, (в) захиалагчаас хамааралгүй болохоо нотолсон тохиолдолд АХБ-ны төслийн худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй болно.
- 4.5 Тендерт оролцогч нь захиалагчаас хүсэлт гаргасан тухай бүрт, эрх бүхий оролцогч мөн болохоо үргэлжлүүлэн хангаж байгаа нотолгоог бичгээр мэдэгдэх ёстой.
- 4.6 НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс НҮБ-ын Дүрмийн 7-р бүлгийн дагуу гаргасан шийдвэртэй холбоотой баримтыг үндэслэн, Зээлдэгч нь энэхүү шийдвэрт хамрагдсан тийм улсаас ямар нэг бараа импортлох, ажил эсхүл үйлчилгээ авахаар гэрээ байгуулах, тийм улсын иргэд болон аж ахуй нэгжид ямар нэгэн төлбөр хийх зэргийг хориглосон бол тухайн компанийг хасна.
- 4.7 Дараах тохиолдолд тендерт оролцогч (эсхүл түншлэлийн гишүүн)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:
- 4.7.1 Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;
- 4.7.2 Монгол улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж буюу бусад төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;
- 4.7.3 Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;
- 4.7.4 Тендерт оролцогч (туслан гүйцэтгэгчийг оролцуулан) нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;
- 4.7.5 Энэхүү тендер шалгаруулалтад оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тооны тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;
- 4.7.6 Энэхүү тендерийн баримт бичгийн ТООЗ-ны 14 дүгээр зүйлд хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тендерт оролцогч нэгээс дээш тендер ирүүлсэн бол. Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй.

- 4.8 Тендерт оролцогч 4.7.1 - 4.7.6-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас зохих үндэслэлтэйгээр хүсэлт тавьсны дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.
- 5 Эрх бүхий бараа ба холбогдох үйлчилгээ**
- 5.1 Бүх бараа ба холбогдох үйлчилгээ нь АХБ-ны эрх бүхий улсын (Эрх бүхий орнууд буюу Тавдугаар бүлгийг үзнэ үү) гарал үүсэлтэй байна.
- 5.2 Энэ заалтын зорилгыг хангах үүднээс, “бараа” гэдэгт түүхий эд-бараа, түүхий эд, машин механизм, тоног төхөөрөмж болон аж үйлдвэрийн дамжлага байгууламжийг оруулна. “Холбогдох үйлчилгээ” гэдэгт даатгал, тээвэрлэлт, угсралт, суурилуулалт, ашиглалтанд оруулах, сургалт болон анхны засвар үйлчилгээ хамаарна.
- 5.3 “Барааны гарал үүсэл” гэдэг нь тухайн барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн улс буюу газар нутгийг хэлнэ. Хийж бүтээсэн гэдэг нь үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, уг эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.
- 5.4 Барааг үйлдвэрлэсэн, угсарсан, нийлүүлсэн эсхүл худалдсан компанийн улсаар барааны гарал үүслийг тодорхойлохгүй.
- 6. Түншлэл**
- 6.1 Хоёр ба түүнээс дээш хуулийн этгээд түншлэлийн үндсэн дээр тендерт хамтран оролцож, тендер ирүүлэх тохиолдолд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- (а) Түншлэлийн бүх гишүүний хувьд хамтаар болон дангаар хариуцлага хүлээнэ;
- (б) Түншлэлийн хэлбэрээр гэрээ байгуулах хүслийг илэрхийлсэн албан захидал эсхүл хүчин төгөлдөр түншлэлийн гэрээг тендерт хавсаргана;
- (в) Түншлэл нь тендер шалгаруулалтын явцад түншлэлийн нэг ба бүх гишүүдийн нэрийн өмнөөс бүх үйл ажиллагааг төлөөлөн хэрэгжүүлэх эрх бүхий төлөөлөгчийг томилох бөгөөд хэрэв түншлэлд гэрээ хэрэгжүүлэх эрх олгогдсон тохиолдолд төлөөлөгч гэрээ хэрэгжүүлэх хугацаанд мөн энэ эрхээ хэрэгжүүлнэ.

Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

- 7. Тендерийн баримт бичгийн агуулга**
- 7.1 Тендерийн баримт бичиг нь доор дурдсан бүлгүүдийг агуулсан гурван хэсэг бүхий баримт бичиг болон ТООЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу хийгдсэн нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ. Үүнд:
- Нэгдүгээр Хэсэг – Тендер Шалгаруулалтын Горим**
 Нэгдүгээр бүлэг. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа (ТООЗ)
 Хоёрдугаар бүлэг. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (ТШӨХ)
 Гуравдугаар бүлэг. Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт
 Дөрөвдүгээр бүлэг. Тендер шалгаруулалтын маягт
 Тавдугаар бүлэг. Эрх бүхий орнууд
- Хоёрдугаар Хэсэг – Бараа Нийлүүлэлтэд Тавигдах Шаардлага**
 Зургаадугаар бүлэг. Нийлүүлэх хуваарь

Гуравдугаар Хэсэг – Гэрээний Нөхцөл Ба Маягт

Долдугаар бүлэг. Гэрээний ерөнхий нөхцөл
Наймдугаар бүлэг. Гэрээний тусгай нөхцөл
Есдүгээр бүлэг. Гэрээний маягт

- 7.2 Захиалагчаас гаргасан тендерийн урилга нь тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.
- 7.3 Хэрэв тендерийн баримт бичиг болон түүний хавсралтуудыг тендерт оролцогч нь захиалагчаас шууд аваагүй бол тэдгээр баримт бичгийн бүрэн байхтай холбоотой хариуцлагыг захиалагч хүлээхгүй.
- 7.4 Тендерт оролцогч тендерийн баримт бичгийн бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх нь зүйтэй. Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх, маягтыг дутуу бөглөн ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болж болно.
- 8 Тендерийн баримт бичгийг тодруулах**
- 8.1 Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр гаргаж, ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар ирүүлнэ. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ТШӨХ-д заасан хоногийн өмнө хүлээн авсан хүсэлтэд хариу өгнө. Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчдод бичгээр нэгэн зэрэг мэдэгдэнэ.
- 8.2 Тухайн тодруулгын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл энэхүү ТООЗ-ны 9 ба 25.2-т заасан горимыг баримтална.
- 9 Тендерийн баримт бичгийг өөрчлөх**
- 9.1 Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичгийг өөрчилж болно.
- 9.2 Ийнхүү оруулсан аливаа өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчдод бичгээр нэгэн зэрэг мэдэгдэнэ. Тендерт оролцогч өөрчлөлт бүрийг хүлээн авсан тухайгаа захиалагчид бичгээр мэдэгдэх үүрэгтэй.
- 9.3 Тендерийн баримт бичигт орсон өөрчлөлтийн улмаас тендер зайлшгүй өөрчлөгдөх ба уг өөрчлөлтийг бэлтгэхэд шаардагдах хангалттай хугацаа тендерт оролцогчдод олгох шаардлагатай гэж үзвэл захиалагч ТООЗ-ны 25.2-т заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

- 10 Тендер шалгаруулалтад оролцох зардал**
- 10.1 Тендерт оролцогч тендер бэлтгэх, захиалагчид ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.
- 11 Тендерийн хэл**
- 11.1 Тендер, түүнчлэн тендертэй холбоотойгоор захиалагч ба тендерт оролцогчийн хооронд солилцсон албан бичиг, захидал болон бусад бүх холбогдох баримт бичиг нь ТШӨХ-д заасан хэл дээр байна.
- 11.2 Аливаа тендерийн дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тендерт оролцогч тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТООЗ-ны 11.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн

орчуулгыг давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг тендерийг хянан үзэх, үнэлэхэд харгалзана.

- 12 Тендерийн иж бүрдэл**
- 12.1 Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
- (а) ТООЗ-ны 13, 15 ба 16 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн тендер ирүүлэх маягт ба зохих үнийн хуваарь;
 - (б) шаардлагатай бол ТООЗ-ны 22 дугаар зүйлд заасны дагуу ирүүлэх тендерийн баталгаа;
 - (в) хэрэв зөвшөөрсөн бол ТООЗ-ны 14 дүгээр зүйлийн дагуу ирүүлэх хувилбарт тендер;
 - (г) тендерт оролцогчийг төлөөлж ТООЗ-ны 23 дугаар зүйлд заасны дагуу тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл;
 - (д) ТООЗ-ны 17 дугаар зүйлд заасны дагуу тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг нотлох баримтууд;
 - (е) ТООЗ-ны 19 дүгээр зүйлд заасны дагуу бараа ба холбогдох үйлчилгээ нь эрх бүхий эсэхийг нотлох баримтууд;
 - (ё) ТООЗ-ны 18 дугаар зүйлд заасны дагуу тендерт оролцогч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг нотлох баримтууд;
 - (ж) ТООЗ-ны 20 ба 32 дугаар зүйлд заасны дагуу нийлүүлэх бараа ба холбогдох үйлчилгээ нь тендерийн баримт бичигт нийцэж буйг нотлох баримт;
 - (з) ТШӨХ-д заасан бусад баримт бичиг.
- 13 Тендер ирүүлэх маягт ба үнийн хуваарь**
- 13.1 Тендерт оролцогч нь Дөрөвдүгээр бүлэг дэх тендер ирүүлэх маягтыг бөглөж ирүүлнэ. Энэхүү маягтыг бөглөхдөө түүний агуулгыг өөрчлөлгүйгээр түүнд шаардсан бүх мэдээллийг тусгана. Аливаа орлуулах явдлыг хүлээн зөвшөөрөхгүй. Бүх хоосон зайнд шаардлагатай мэдээллийг оруулна.
- 13.2 Тендерт оролцогч нь нийлүүлэх бараа болон холбогдох үйлчилгээний үнийн хуваарийг түүний гарал үүслээс нь хамааран Дөрөвдүгээр бүлэгт заасан тохирох маягтыг ашиглан бэлтгэж ирүүлнэ.
- 14 Хувилбарт тендер**
- 14.1 ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн зөвхөн нэг тендер ирүүлэх ба хувилбарт тендер ирүүлэхийг үл зөвшөөрнө.
- 15 Тендерийн үнэ ба хөнгөлөлт**
- 15.1 Тендер ирүүлэх маягт болон үнийн хуваарь дахь тендерт оролцогчийн санал болгож буй үнэ болон үнийн хөнгөлөлт нь доор тодорхойлсон шаардлагад нийцсэн байна.
- 15.2 Бүх багц болон нэр төрлийг үнэ тус бүрээр нь тусад нь Дөрөвдүгээр бүлэг дэх үнийн хуваарьт жагсааж ирүүлнэ. Хэрэв үнийн хуваарьт нэр төрлийг жагсаахдаа үнийг нь харуулаагүй бол тэдгээрийн үнийг өөр нэр төрлийн үнэд багтаасан гэж үзнэ. Үнийн хуваарийн жагсаалтанд оруулаагүй нэр төрлийг тендерт оруулаагүй гэж үзэх боловч уг тендерийг үндсэнд нь

шаардлага хангасанд тооцож ТООЗ-ны 33.3-т заасны дагуу холбогдох тохируулгыг хийнэ.

15.3 Тендер ирүүлэх маягтад тусгасан үнэ нь аливаа үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.

15.4 Тендерт оролцогч нь аливаа нөхцөлт бус үнийн хөнгөлөлт болон түүнийг хэрэглэх аргачлалыг тендер ирүүлэх маягтад тусад нь тусгасан байна.

15.5 Олон улсын худалдааны EXW, CIF болон ижил төстэй бусад нөхцлийг хэрэглэхдээ ТШӨХ-д дурдсан, Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргасан Incoterms-ийн хамгийн сүүлийн хувилбарыг удирдлага болгоно.

15.6 Нийлүүлэх барааны үнийг Дөрөвдүгээр бүлэг буюу “Тендер шалгаруулалтын маягт”-ын үнийн хуваарь бүрээр гаргаж ирүүлнэ. Ингэхдээ тендерт оролцогч нь гэрээний дагуу нийлүүлэх барааны нэгж үнэ, тухайн нэр төрлийн нийт үнэ, нийт дүн, барааны гарал үүслийн улсын нэрийг бараа хүргэх хуваарьт заасан нэр төрөл бүрээр холбогдох үнийн хуваарьт тусгана. Үнийн задаргааны агуулга нь захиалагчаас тендерийг харьцуулж үнэлэх зорилгоор шаардагдана.

15.7 Гэрээ болон бусад үндэслэлээр нийлүүлэгчийн төлөх ёстой бүх татвар хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үндэслэн тендерийн үнэд багтаасан байна. Тендерт оролцогч гэрээний дагуу нийлүүлэх барааны нэгж үнэ, тухайн нэр төрлийн нийт үнэ, нийт дүн, барааны гарал үүслийн улсын нэрийг хүргэх хуваарьт заасан нэр төрөл тус бүрээр холбогдох үнийн хуваарьт тусгана.

15.8 Үнийн хуваарьт дараах зүйлсийг тусад нь бичиж харуулна. Үүнд:

(а) Монгол улсад үйлдвэрлэгдсэн барааны хувьд:

(1) EXW нөхцлөөр илэрхийлэгдсэн барааны үнэ (үйлдвэрийн, агуулахын, эсхүл лангууны үнийн аль тохирохыг). Энэ үнэд барааг үйлдвэрлэх, угсрахад ашигласан үйлдвэрийн, эсхүл лангууны үнээр үнэлэгдсэн эд анги, түүхий эд, үйлдвэрлэлийн бусад өртөг багтана;

(2) гэрээ байгуулах эрх олгогдсоноор дотоодын бүтээгдэхүүнд ногдуулдаг нэмэгдсэн өртгийн болон бусад адилтгах албан татвар;

(3) ТШӨХ-д заасан эцсийн цэгт барааг хүргэхэд шаардагдах хуурай газрын тээврийн үнэ, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

(б) Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд импортоор орж ирэх барааны хувьд:

(1) ТШӨХ-д заасан захиалагчийн улсын нэрлэсэн хилийн боомт хүртэлх CIF үнэ, эсхүл захиалагчийн нутаг дэвсгэр дэх нэрлэсэн байрлал хүртэлх CIF үнэ;

(2) гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирэх бараанд ногдох гаалийн, нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;

(3) барааг орох боомтоос буюу нэрлэсэн байрлалаас ТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардагдах хуурай газрын тээврийн үнэ, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

(в) Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд өмнө нь импортоор орж ирсэн барааны хувьд:

(1) барааны үнэ буюу импортоор анх орж ирсэн тухайн барааны үнэ дээр үнийн нэмэгдэл эсхүл хөнгөлөлт, дотоодод гарсан аливаа нэмэлт зардал, тухайн бараанд төлсөн эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татваруудыг тооцсон үнэ;

(2) импортлогдсон бараанд урьд нь төлсөн (нотлох баримтыг хамтад нь ирүүлэх шаардлагатай), эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татварууд;

(3) дээрх дурдсан 1 ба 2 дах заалтын хоорондын барааны зөрүү үнэ;

(4) гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирсэн бараанд ногдох нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;

(5) ТШӨХ-д заасан эцсийн цэгт барааг хүргэхэд шаардагдах хуурай газрын тээврийн үнэ, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

(г) Барааны техникийн тодорхойлолт болон холбогдох үйлчилгээний шаардлагад заасан холбогдох үйлчилгээний хувьд:

(1) Холбогдох үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн зардлын өртгийг харуулна.

15.9 ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх ба үл өөрчлөгдөнө. Тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулж өөрчлөхөөр санал болгосон аливаа тендерийг ТООЗ-ны 32 дугаар зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана. Хэрэв ТШӨХ-д заасны дагуу тендерт оролцогч гэрээний хэрэгжилтийн явцад үнийг тохируулахаар заасан бол тогтмол үнийн саналтай тендерээс татгалзахгүй, гэхдээ үнийн тохируулгыг тэгтэй тэнцүүлж үзнэ.

15.10 ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан бол үнэ тохируулах нөхцөл, аргачлалыг ГТН-д тусгана.

16 Тендерийн ба төлбөрийн валют

16.1 Тендерийн ба төлбөрийн валют нь Монгол төгрөг байна.

17 Тендерт оролцогчийн эрх бүхий эсэхийг нотлох баримт

17.1 Тендерт оролцогчийн эрх бүхий эсэхийг ТООЗ-ны 4 дүгээр зүйлд заасны дагуу дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Үүнд:

(а) “Тендер шалгаруулалтын маягт” буюу Дөрөвдүгээр бүлэгт тусгагдсан Тендер ирүүлэх маягтын эрх бүхий эсэх хэсгийг бөглөсөн мэдэгдэл;

(б) хэрэв тендерт оролцогч ТООЗ-ны 6 дугаар зүйлд заасны дагуу түншлэлийн хэлбэрээр оролцож байгаа бол түншлэлийн гэрээ байгуулах тухай хүслийг илэрхийлсэн албан захидал эсхүл хүчин төгөлдөр түншлэлийн гэрээ;

(в) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

(г) тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн эрхийн баталгаа буюу итгэмжлэл;

(д) ТШӨХ-д шаардсан бол тухайн төрлийн бараа нийлүүлэх тусгай зөвшөөрөл.

18. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт

18.1 Тендерт оролцогч нь гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан захиалагчийн шаардсан чадварын шаардлагыг хангасан гэдгээ харуулах дараах мэдээллийг нотлох баримт болгон ирүүлнэ. Үүнд:

(а) Тендерт оролцогчийн тендерийг хүлээн авсан тохиолдолд түүний тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг нь тогтооход шаардлагатай нотлох баримтууд нь тендерт оролцогчийг “Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт” буюу Гуравдугаар бүлэгт тодорхойлсон чадварын шалгуур тус бүрийг хангасан гэдгийг захиалагчид харуулахуйц байна.

(б) хэрэв ТШӨХ-д шаардсан бол тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг тендерт санал болгох тохиолдолд уг барааг Монгол улсад нийлүүлэх эрх олгосон тухай үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг Дөрөвдүгээр бүлэг дэх маягтын дагуу бөглөж ирүүлнэ;

(в) хэрэв ТШӨХ-д шаардсан бол Монгол улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй тендерт оролцогч гэрээний нөхцөл эсхүл техникийн тодорхойлолтод заасны дагуу засвар үйлчилгээ хийх, сэлбэг хэрэгсэл нийлүүлэх үүргийг түүнийг төлөөлсөн төлөөлөгч хийж гүйцэтгэх тухай баримт.

19. Бараа ба холбогдох үйлчилгээ нь эрх бүхий эсэхийг нотлох баримт

19.1 ТООЗ-ны 5-д заасны дагуу бараа ба холбогдох үйлчилгээ нь эрх бүхий эсэхийг нотлохын тулд тендерт оролцогч нь “Тендер шалгаруулалтын маягт” буюу Дөрөвдүгээр бүлгийн үнийн хуваарьт гарал үүслийн талаарх мэдэгдлийг бөглөнө.

20. Бараа ба холбогдох үйлчилгээ нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэж буй эсэхийг нотлох баримт

20.1 Тендерт оролцогч нь түүний нийлүүлэх бараа ба холбогдох үйлчилгээ “Нийлүүлэх хуваарь” буюу Зургаадугаар бүлэгт заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг нотлох баримтыг тусгайлан бэлтгэж, тендерт тусган ирүүлнэ. Ийм баримт нь нийтлэл, зураг, өгөгдлийн хэлбэрээр байж болох ба дараах мэдээллийг агуулна. Үүнд:

(а) барааны техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт;

(б) ТШӨХ-д заасан жилийн хугацаанд барааг тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах аливаа сэлбэг хэрэгсэл, тусгай багажнуудын жагсаалт. Тус жагсаалтад тэдгээрийг хаанаас нийлүүлэх боломжтой болон нэгж үнэ зэрэг холбогдох мэдээллийг дурдана;

(в) нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдэл;

(г) захиалагчийн техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал ба тоног төхөөрөмжийн стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр

хязгаарлагдахгүй. Тендерт өөр стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь Нийлүүлэх хуваарь буюу Зургаадугаар бүлэгт заасантай дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч захиалагчид нотлон харуулна.

21. Тендер хүчинтэй байх хугацаа

21.1 Тендер нь захиалагчийн ТООЗ-ны 25 дугаар зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ТШӨХ-д тусгайлан заасан хоногийн хугацаанд хүчинтэй байна. Аливаа тендерийн хүчинтэй байх хугацаа нь захиалагчийн тогтоосон хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүнийг үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж татгалзана.

21.2 Захиалагчаас үл хамаарах шалтгаанаар онцгой нөхцөл байдал үүсч тендер хүчинтэй байх хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд, захиалагч бүх тендерт оролцогчдод хандаж тендерийн хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлтийг тавина. Энэхүү хүсэлт болон түүний хариуг бичгээр үйлдэнэ. Тендерт оролцогч хүсэлтээс татгалзвал тендерийн баталгааг улсын орлого болгохгүй. Хүсэлтийг зөвшөөрсөн тендерт оролцогч тендерийн агуулгыг өөрчлөхийг санал болгох, эсхүл өөрчилж болохгүй. Хүсэлтийг зөвшөөрсөн тендерт оролцогч тендерийн баталгааны хүчинтэй хугацааг ТООЗ-ны 22 дугаар зүйлд нийцүүлэн сунгана.

22. Тендерийн баталгаа

22.1 Хэрэв ТШӨХ-д тендерийн баталгаа шаардсан бол тендерт оролцогч эрх бүхий улсын нэр хүндтэй банкнаас гаргасан, ТШӨХ-д заасан дүнтэй тендерийн баталгааг тендерийн саналын нэг хэсэг болгон доор дурдсан хэлбэрээр, эх хувиар ирүүлнэ:

(а) Банкны баталгаа, эсхүл

(б) Баталгааг чек болон бэлэн мөнгөний чек.

Банкны баталгааны хувьд тендерийн баталгааг “Тендер шалгаруулалтын маягт” буюу Дөрөвдүгээр бүлэг дэх Тендерийн баталгааны маягтын дагуу, эсхүл захиалагчаас хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ. Маягтад тендерт оролцогчийн бүтэн нэрийг тусгана. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх эцсийн хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Хэрэв тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол энэ нь нэгэн адил үйлчилнэ.

22.2 Түншлэлийн хувьд тендерийн баталгааг тендер ирүүлсэн түншлэлийн нэр дээр гаргуулна.

22.3 ТООЗ-ны 22.1 ба 22.2-г заасан шаардлагад нийцсэн тендерийн баталгаа ирүүлээгүй аливаа тендерээс захиалагч үндсэн шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.

22.4 ТООЗ-ны 43 болон 44 дүгээр зүйлийн дагуу шалгарсан тендерт оролцогч гарын үсэг зурагдсан гэрээ ба гүйцэтгэлийн баталгааг ирүүлмэгц шалгараагүй тендерт оролцогчийн тендерийн баталгааг нэн даруй буцаан олгоно.

22.5 Шалгарсан тендерт оролцогч гэрээнд гарын үсэг зурж, шаардсан гүйцэтгэлийн баталгааг ирүүлсний дараа шалгарсан тендерт оролцогчийн тендерийн баталгааг нэн даруй буцаан олгоно.

22.6 Тендерийн баталгааг дараах тохиолдолд улсын орлого болгоно. Үүнд:

(а) ТООЗ-ны 21.2-т зааснаас бусад нөхцөлд тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан, эсхүл буцааж авахыг бичгээр мэдэгдсэн;

(б) хэрэв шалгарсан тендерт оролцогч ТООЗ-ны 34-ийн дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол;

(в) хэрэв шалгарсан тендерт оролцогч заасан хугацаанд багтаан:

1) ТООЗ-ны 43 дугаар зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зураагүй; эсхүл

2) ТООЗ-ны 44 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол.

23 Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах

23.1 Тендерт оролцогч ТООЗ-ны 12 дугаар зүйлд заасан тендерийн иж бүрдэл баримт бичгүүдийн нэг эх хувийг бэлтгэн хавтаслаж, түүнд “ЭХ ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Тендерт оролцогч үүнээс гадна ТШӨХ-д заасан тоо ширхэг бүхий тендерийн хуулбар хувийг бэлтгэн хавтаслаж “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Эх ба хуулбар хувийн хооронд зөрүүтэй тохиолдолд эх хувийг баримтална.

23.2 Тендерийн эх болон хуулбар хувиудыг хэвлэж, эсхүл арилдаггүй бэхээр бичиж, тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулна. Тендерт оролцогчийн боловсруулсан тендерийн агуулга, үнэтэй холбоотой бүх хуудсанд төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурна. Хэвлэмэл танилцуулга, тайлан болон бусад байгууллагын гаргасан албан ёсны мэдээлэл зэрэг баримт бичиг үүнд хамаарахгүй.

23.3 Тендер ирүүлэхээс өмнө захиалагчийн гаргасан зааварчилгаатай нийцүүлэх, эсхүл тендерт оролцогч өөрийн алдааг зайлшгүй шаардлагаар засахаас бусад тохиолдолд тендерт ямар нэгэн засвар, нэмэлт бичилт хийхгүй ба засвар, нэмэлт бичилт хийсэн тохиолдолд зөвхөн дээрх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар тэдгээр засвар, өөрчлөлтийг хүчинтэйд тооцно.

Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ

24 Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх

24.1 Тендерт оролцогч өөрийн тендерийг шуудангаар, эсхүл өөрийн бие төлөөлөгчөөр захиалагчид хүргүүлнэ. ТШӨХ-д заасан бол тендерт оролцогч тендерийг цахим хэрэгслээр дамжуулан хүргэж болно.

24.2 Тендерийн эх болон хуулбар хувиудыг тус тусад нь “ЭХ ХУВЬ”, “ХУВИЛБАР ТЕНДЕР”, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэн тэдгээрийг дахин нэг (гаднах) дугтуйнд давхарлан хийж битүүмжилнэ. Тендерээ дугтуйлан битүүмжлэхдээ ТООЗ-ны 24.3 ба 24.4–т заасныг баримтална.

24.3 Доторх ба гаднах дугтуйнууд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

(а) тендерт оролцогчийн нэр, хаягтай байх;

(б) ТШӨХ-д заасан хаягаар ТООЗ-ны 1.1-т заасан захиалагчийн нэр дээр хаяглах;

(в) тендер шалгаруулалтыг таних, ялгах тэмдэг болгож ТООЗ-ны 1.1 болон ТШӨХ-д тодорхойлсон тендер шалгаруулалтын дугаарыг тодорхой бичсэн байх;

(г) ТООЗ-ны 28.1-д заасан хугацаанаас өмнө “НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэж тэмдэглэгдсэн байх.

24.4 Хэрэв бүх дугтуйг 24.3-т заасан шаардлагын дагуу битүүмжилж, бичиглэл хийгээгүй нөхцөлд уг тендер буруу хаягаар хүргэгдсэн, эсхүл тендер нээхээс өмнө битүүмжлэл задарсан тохиолдолд захиалагч хариуцлага хүлээхгүй.

24.5 ТООЗ-ны 24.1-д зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн аливаа тендерийг захиалагч хүлээж авахгүй бөгөөд түүнийг хаягаар нь буцаана.

24.6 Цахим хэрэгслээр дамжуулан тендерийг хүргүүлж байгаа тендерт оролцогч ТШӨХ-д заасан цахим хэрэгслээр тендер хүргүүлэх горимыг баримтлана.

25 Тендер хүлээн авах эцсийн хугацаа 25.1 Захиалагч тендерүүдийг ТООЗ-ны 24.3(б)-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

25.2 Захиалагч ТООЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.

26 Хугацаа хоцорсон тендер 26.1 Захиалагч ТООЗ-ны 25 дугаар зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг “хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр тендерт оролцогчдоод буцаана.

27 Тендерийг буцааж авах, солих, өөрчлөх 27.1 Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчид бичгээр мэдэгдэл өгсний үндсэн дээр өөрийн тендерийг буцааж авах, солих, эсхүл өөрчлөх эрхтэй.

27.2 Тендерийг буцааж авах, солих, өөрчлөх мэдэгдлийг ТООЗ-ны 23 ба 24 дүгээр зүйлийн дагуу бэлтгэн битүүмжилж, бичиглэл хийн ирүүлэхийн хамт доторх ба гаднах дугтуйн дээр “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ”, “ТЕНДЕРИЙГ СОЛИХ”, эсхүл “ТЕНДЕРИЙГ ӨӨРЧЛӨХ” гэж бичнэ. Бүх мэдэгдлийг бичгээр ирүүлэх ба энэ мэдэгдэл хүчин төгөлдөр болохыг батламжилж гарын үсэг, тамга бүхий эх хувийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө заавал ирүүлнэ.

27.3 Тендер хүлээн авах эцсийн хугацаа өнгөрсөнөөс хойш аливаа тендерийг буцааж авах, солих, эсхүл өөрчлөхийг зөвшөөрөхгүй.

27.4 ТООЗ-ны 27.2-т заасны дагуу тендерээ буцааж авах тухай хүсэлт ирүүлсэн оролцогчийн тендерийг нээлгүйгээр буцаан олгоно.

27.5 Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас тендер хүчинтэй байх хугацааны хооронд ямар ч тендерийг буцааж авах, солих, эсхүл өөрчлөхийг хориглоно.

Д. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ

28 Тендерийг нээх 28.1 Захиалагч тендерийн нээлтийг ТШӨХ-д заасан огноо ба цагт, заасан газарт зохион байгуулна. Тендер нээх үед тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй ба байлцсан бол тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсгээ зурна.

28.2 Захиалагч эхлээд “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ” гэсэн бичиглэл бүхий дугтуйг нээж зарлах бөгөөд энэ хүсэлтийг ирүүлсэн оролцогчийн тендерийг нээлгүйгээр буцаана. Дараа нь “ТЕНДЕРИЙГ СОЛИХ” бичиглэл бүхий тендерийг нээж зарлах бөгөөд уг тендерт оролцогчоос өмнө нь ирүүлсэн тендерийг нээлгүйгээр буцаан олгоно. “ТЕНДЕРИЙГ ӨӨРЧЛӨХ” бичиглэл бүхий дугтуйг түүнд холбогдох тендерийн хамт нээж нийтэд зарлана.

28.3 Тендерийг нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, санал болгосон бол үнийн хөнгөлөлт, хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд түүний үнэ, тендерийн баталгаа байгаа эсэх, оролцогч өөрийн тендерийг өөрчилсөн бол уг өөрчлөлтийг болон захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. Тендер нээх үед зарлагдаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзахгүй.

28.4 Захиалагч тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд уг тэмдэглэл нь дараах мэдээллийг заавал агуулсан байна. Үүнд:

(а) тендерт оролцогчийн нэр болон тухайн тендерт оролцогч тендерээ буцааж авсан, сольсон, эсхүл өөрчилсөн эсэх;

(б) тендерийн үнэ болон санал болгосон үнийн хөнгөлөлт (зөвшөөрсөн бол хувилбарт тендерийн үнэ). Нэгээс дээш багцтай тендер шалгаруулалтын үед эдгээр мэдээллийг багц тус бүрээр гаргах;

(в) захиалагч тендерийн баталгаа шаардсан бол түүнийг ирүүлсэн эсэх.

29 Нууцлал

29.1 Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах, чадварыг дахин магадлах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчдод болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.

29.2 Захиалагч тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах, чадварыг дахин магадлах явцад, эсхүл гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт тендерт оролцогчоос нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болно.

29.3 Тендерийн нээлт хийснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд захиалагч болон тендерт оролцогч нь хоорондоо зөвхөн бичгээр харилцана.

30 Тендерийг тодруулах

30.1 Тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах болон чадварыг дахин магадлах явцад зайлшгүй шаардлагатай бол захиалагч тендерт оролцогчоос түүний тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно. Тендерийг тодруулахтай холбоотой аливаа харилцааг бичгээр явуулна. Гэхдээ ТООЗ-ны 34-ийн дагуу тендерийг хянан үзсэний үндсэн дээр захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахаас бусад тохиолдолд тендерийн үнэ болон агуулгад ямар нэгэн өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй.

31. Зөрүү, болзолт нөхцөл ба орхигдуулсан зүйл

31.1 Тендер үнэлэх явцад дараах ойлголтууд хэрэглэгдэнэ:

(а) “Зөрүү” гэдэг нь тендерийн баримт бичигт заасан шаардлагаас өөр аливаа ялгааг хэлнэ.

(б) “Болзолт нөхцөл” гэдэг нь хязгаарлагдмал нөхцөл тогтоох эсхүл тендерийн баримт бичигт заасан шаардлагыг бүрэн хүлээн зөвшөөрөхөөс татгалзахыг хэлнэ.

(в) “Орхигдуулсан зүйл” гэдэг нь тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл эсхүл баримт бичгийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нь ирүүлэхгүй байх алдааг хэлнэ.

32. Тендерийг хянан үзэж, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох

32.1 Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө, ТООЗ-ны 12-т дурдсаны дагуу уг тендер нь агуулгын хувьд шаардлагыг хангаж буй эсэхийг хянан үзнэ.

32.2 Шаардлагад нийцсэн тендер гэдэг нь тендерийн баримт бичигт дурдсан бүх шаардлагыг том зөрүү, болзолт нөхцөл болон орхигдуулсан зүйлгүйгээр хангаж буй тендерийг хэлнэ. Доор дурдсан зүйлсийг том зөрүү, болзолт нөхцөл ба орхигдуулсан зүйл гэж үзнэ. Үүнд:

(а) Нийлүүлэх хуваарь буюу Зургаадугаар бүлэгт тодорхойлсон бараа ба холбогдох үйлчилгээний хамрах хүрээ, чанар ба гүйцэтгэлд их хэмжээгээр нөлөөлөхөөр бол;

(б) гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүргийг тендерийн баримт бичигтэй үл нийцсэн байдлаар их хэмжээгээр хязгаарлах бол;

(в) шаардлагад үндсэндээ нийцэж байгаа бусад тендерт оролцогчийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх үүднээс засаж засварласан бол.

32.3 Захиалагч тендерийн баримт бичгийн шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Харин тендерт оролцогч том зөрүү, болзолт нөхцөл болон орхигдуулсан зүйлийг засаж засварлах замаар тендерийг шаардлагад нийцсэн болгож болохгүй.

32.4 Захиалагч “Нийлүүлэх хуваарь” буюу Зургаадугаар бүлэгт тусгасан шаардлагыг том зөрүү эсхүл болзолт нөхцөлгүйгээр хангаж байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс техникийн тодорхойлолтыг хянан үзнэ.

33. Жижиг зөрүү

33.1 Хэрэв тендерийг үндсэндээ шаардлага хангасанд тооцсон бол түүний аливаа зөрүү, болзолт нөхцөл эсвэл орхигдуулсан зүйл нь том шинжийг агуулаагүй тийм жижиг зөрүүг захиалагч харгалзахгүй байж болно.

33.2 Хэрэв тендерийг үндсэндээ шаардлага хангасанд тооцсон бол баримтжуулах шаардлагын улмаас тендерийн жижиг зөрүүг засах үүднээс шаардлагатай мэдээлэл эсхүл баримтыг тодорхой хугацаанд ирүүлэхийг захиалагч тендерт оролцогчоос хүсч болно. Гэхдээ ийм зөрүүний талаарх мэдээлэл эсхүл баримтыг хүсэх нь тендерийн үнэд огтхон ч нөлөөлөх ёсгүй. Тендерт оролцогч ийм хүсэлтийг биелүүлээгүй нь уг тендерээс татгалзах үндэслэл болно.

33.3 Хэрэв тендерийг үндсэнд нь шаардлага хангасанд тооцсон бол захиалагч тендерийн үнэд хамааралтай, тоогоор илэрхийлэгдэж болохуйц жижиг зөрүүг засаж залруулна. Үүний үр дүнд орхигдуулсан эсхүл нийцээгүй зүйл эсхүл бүрэлдэхүүн хэсгийн үнийг тусгахын тулд зөвхөн харьцуулах зорилгоор тендерийн үнэд залруулга хийнэ. Залруулга хийхдээ “Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт” буюу Гуравдугаар бүлэгт тодорхойлсон аргачлалыг хэрэглэнэ.

- 34. Арифметик алдааг залруулах**
- 34.1 Захиалагч шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна. Үүнд:
- (а) тоогоор болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрүүтэй бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэх;
 - (б) нэгж үнэ ба нийт үнийн хооронд зөрүүтэй бол нэгж үнийг баримтлах бөгөөд нийт үнийг залруулах;
 - (в) нэр төрлийн нийт үнийн нийлбэр ба ялгавар нь алдаатай бол нэр төрлийн нийт үнийг баримтлах бөгөөд нийлбэр эсвэл ялгаврын дараах нийт үнийг залруулах;
 - (г) Үнийн хүснэгтийн нийт үнэ нь тендер ирүүлэх маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үнийн хүснэгтийн нийт үнийг баримтлах бөгөөд тендер ирүүлэх маягтад заасан тендерийн нийт үнийг залруулах;
- 34.2 Захиалагч “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендерийн үнэд залруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчдоод мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг нь бичгээр баталгаажуулж авна.
- 35 Нэг валютад хөрвүүлэх**
- 35.1 ТООЗ-ны 16.1-д заасны дагуу тендерийн үнэлгээ, харьцуулалтыг хийхдээ тендерийн үнийг нэг валютад хөрвүүлэхгүй.
- 36 Давуу эрхийн зөрүү**
- 36.1 Тендерийн үнэлгээнд давуу эрхийн зөрүүг тооцохгүй.
- 37 Тендерийг үнэлэх, харьцуулах**
- 37.1 Захиалагч зөвхөн ТООЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу шаардлагад нийцсэн гэж тогтоогдсон тендерийг үнэлж, харьцуулна.
- 37.2 Захиалагч тендерийг үнэлэхдээ дараах байдлаар тендерийн үнэд залруулга хийж, тендерийн харьцуулах үнийг тодорхойлно. Үүнд:
- (а) ТООЗ-ны 34 дүгээр зүйлийн дагуу арифметик алдааг тооцож тендерийн үнийг залруулах;
 - (б) ТООЗ-ны 32.2 дугаар зүйлийн дагуу том зөрүү гэж тооцоогүй бага хэмжээний орхигдуулсан зүйл буюу тоо хэмжээний зөрүүг тооцон мөнгөөр илэрхийлэх байдлаар тендерийн үнэд залруулга хийх;
 - (в) тендерт оролцогчийн санал болгосон нэмэлт, өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тусгах;
 - (г) захиалагч Гуравдугаар бүлэгт заасан үнэлгээний шалгуур үзүүлэлтийг холбогдох аргачлалын дагуу тооцон мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэд залруулга хийх;
- 37.3 Шаардлагад нийцсэн тендерүүдийг 37.2-т заасны дагуу үнэлгээ хийж тендер тус бүрийн харьцуулах үнийг тогтооно. Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж шалгаруулна.
- 37.4 ТООЗ-ны 14-т заасны дагуу хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн үндсэн тендерийн хувилбарт тендер үндсэн тендерээс илүү нөхцөл хангасан бол хувилбарт тендерийг шалгаруулна.

- 37.5 ТООЗ-ны 1.2-т барааг хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг багц тус бүрт хийх бөгөөд харин гэрээ байгуулах эрх олгохдоо нэг багц, хэд хэдэн багц, эсхүл бүх багцын аль ашигтай хувилбарыг сонгож болно.
- 37.6 Олон багцтай тендер шалгаруулалтад “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендерийг шалгаруулж, тэдгээрт гэрээ байгуулах эрх олгох хамгийн ашигтай хувилбарыг сонгохдоо захиалагч Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт буюу Гуравдугаар бүлэгт олон багцтай тендерийг үнэлэх талаар тусгайлан заасан аргачлалыг мөрдөнө.
- 38 Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах**
- 38.1 Захиалагч шаардлагад нийцсэн, “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлаж болно.
- 38.2 Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлохдоо ТООЗ-ны 18-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТООЗ-ны 30 дугаар зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн чадварын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлно. Захиалагч ТООЗ-ны 18 дугаар зүйл болон тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.
- 38.3 “Хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадласны дараа шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзан “сайн” гэж үнэлэгдсэн дараагийн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.
- 39 Аливаа тендерийг хүлээн зөвшөөрөх, мөн бүх эсхүл аливаа тендерээс татгалзах захиалагчийн эрх**
- 39.1 Захиалагч аливаа тендерийг хүлээн зөвшөөрөх, эсхүл татгалзах, мөн тендер шалгаруулалтыг хүчингүй болгох, болон гэрээний эрх олгохын өмнө бүх тендерээс татгалзах эрхтэй.

Е. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ

- 40 Гэрээ байгуулах эрх олгох шалгуур**
- 40.1 Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд ТООЗ-ны 37.3-т заасны дагуу “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.
- 40.2 “Хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТООЗ-ны 34 дүгээр зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй бол гэрээ байгуулахаас татгалзсан гэж тооцож, тендерээс татгалзах бөгөөд ТООЗ-ны 22.6(б)-д заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгоно.
- 41 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 41.1 Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид түүний тендерийг хүлээн зөвшөөрсөн тухай шийдвэрийг бичгээр мэдэгдэнэ.

- 41.2 Шалгарсан тухай мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг тооцсон тендерийн үнэ байна.
- 41.3 Захиалагч нь түүнчлэн тендер шалгаруулалтын үр дүнг бусад тендерт оролцогчдод нэгэн зэрэг мэдэгдэнэ. Захиалагч Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хуудсанд тендерийн нэр болон багцын дугаарыг дараах мэдээллийн хамт гэрээ байгуулах эрх олгосон даруйд нь нийтэлнэ. Үүнд:
- 1) тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;
 - 2) тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;
 - 3) нарийвчлан үнэлэгдсэн тендерийн нэр, үнийн санал;
 - 4) тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;
 - 5) тендер нь шалгарсан оролцогчийн нэр, түүний санал болгосон тендерийн үнэ, гэрээний үнийн дүн.
- 41.4 Гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг мэдээлсний дараа шалгараагүй тендерт оролцогч өөрийн тендерийн үнэлгээний талаар тайлбар авах хүсэлтийг бичгээр гаргаж болно. Гэрээний үр дүнг нийтэлж зарласны дараа хүсэлт гаргасан шалгараагүй тендерт оролцогчид захиалагч хариуг бичгээр яаралтай өгнө. Хэрэв захиалагч тендерт оролцогчдоос эсэргүүцэл эсвэл гомдол хүлээн авсан тохиолдолд тухайн гомдлыг сайтар хянан хариуг аль болох түргэн өгнө.
- 41.5 Тендер нь шалгарсан оролцогч ТООЗ-ны 44 дүгээр зүйлийн дагуу гаргасан гүйцэтгэлийн баталгаа гаргаж, гэрээний маягтанд гарын үсэг зурж ирүүлсэн даруйд нь захиалагч ТООЗ-ны 22.5-д заасны дагуу тендерийн баталгааг буцаан олгож, энэ тухай шалгараагүй бусад тендерт оролцогчдод мэдэгдэнэ.
- 42 Эрх олгох үед тоо хэмжээг өөрчлөх захиалагчийн эрх**
- 42.1 Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед тендер болон тендерийн баримт бичигт заасан нэгж үнэ ба бусад нөхцөлийг өөрчлөхгүйгээр техникийн тодорхойлолтод дурдсан барааны тоо ширхэгийг ТШӨХ-д заасан хувиар өөрчлөх эрхтэй.
- 43 Гэрээнд гарын үсэг зурах**
- 43.1 Захиалагч гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцлийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.
- 43.2 Шалгарсан тендерт оролцогч гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хугацаанд багтаан түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.
- 43.3 Захиалагч шалгарсан тендерт оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсний дараа ТООЗ-ны 43.2-т нийцүүлэн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 44 Гүйцэтгэлийн баталгаа**
- 44.1 Шалгарсан тендерт оролцогч Гэрээний маягт буюу Есдүгээр бүлэгт тусгагдсан гүйцэтгэлийн баталгааны маягтыг ашиглан ГЕН-д заасны дагуу гүйцэтгэлийн баталгааг гаргана.
- 44.2 Шалгарсан тендерт оролцогч ТООЗ-ны 44.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох болон тендерийн баталгааг улсын орлого болгох хангалттай үндэслэл болно. Ийм тохиолдолд удаах “хамгийн сайн” үнэлэгдсэн бөгөөд гэрээг хэрэгжүүлэх чадвар бүхий тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх доор дурдсан өгөгдлүүд нь ТООЗ-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТООЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү бүлэгт тусгагдсан мэдээллийг зөв гэж үзнэ. ТШӨХ-ийн зүйл, заалтыг дугаарлахдаа ТООЗ-ны холбогдох зүйл, заалттай ижил дугаарыг хэрэглэнэ.

ТООЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл
ТООЗ 1.1	Захиалагч: <i>Сангийн яам</i>
ТООЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр ба ялгагдах дугаар: <i>ГЗ: Гаалийн Автоматжуулсан Мэдээллийн Системийн Өргөтгөлийн тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах</i>
ТООЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалтыг бүрдүүлж буй багц тус бүрийн нэр ба ялгагдах дугаар: <i>Хамаарахгүй</i>
ТООЗ 2.1	Зээлдэгч: <i>Монгол Улс</i> Санхүүжилтийн эх үүсвэр: <i>Азийн хөгжлийн банкны зээл</i> Төслийн нэр: <i>Л3313-МОН: Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл</i>
	Б. Тендерийн баримт бичиг
ТООЗ 8.1	Захиалагчийн хаяг (зөвхөн тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах зорилгоор): Харилцах албан тушаалтан: <i>Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн Н.Болороо</i> Байгууллага: <i>Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл</i> Гудамж/байр: <i>МН Тауэр, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж-15141,</i> Давхар/өрөө: <i>14 давхар, 1404 тоот өрөө</i> Аймаг/хот: <i>Улаанбаатар хот</i> Улс: <i>Монгол Улс</i> Цахим шуудан: spsproject.procurement@gmail.com coordinator.spsproject@gmail.com Захиалагч тодруулга авах хүсэлтийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 7 хоногийн өмнө хүлээн авна.
	В. Тендер бэлтгэх
ТООЗ 11.1	Тендерийн хэл нь Монгол хэл байна.
ТООЗ 12.1 (з)	<ul style="list-style-type: none"> • Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерийн хамт хавсралтаар ирүүлнэ: • Туршлагаа баталсан баримт бичиг: ажлын гэрээний хуулбарыг хавсралтын хамт ирүүлнэ. • Нийлүүлэгч нь (i) нийлүүлж буй тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчээс нь шууд нийлүүлж, (ii) нийлүүлсний дараах техникийн тусламжийг гуравдагч байгууллагаар дамжуулахгүйгээр үйлдвэрлэгчээс шууд авч захиалагчид нийлүүлэхийг баталсан албан бичиг ирүүлнэ. • Нийлүүлэх тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, тохиргоог хийж гүйцэтгэх 2 болон түүнээс дээш мэргэжлийн инженер, техникийн

	<p>ажилтантай байна. Инженер тус бүрийн сүүлийн 2 жилийн /2022, 2023/ НД тайлан хавсаргаж ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэгчийн албан ёсны сургалтад хамруулсан 1 инженертэй байх. Нотлох баримтыг ирүүлнэ.
ТООЗ 14.1	Хувилбарт тендер ирүүлэхийг “зөвшөөрөхгүй”
ТООЗ 15.5	Инкотермс /Incoterms/-ийн хувилбар: 2020
ТООЗ 15.8 (а) (3);(б)(3) болон (в)(5)	<p>“Бараа хүргэгдэх эцсийн цэг (Захиалагчийн агуулах, эсхүл барааг эцсийн хэрэглэгчид хүргэх байршил):</p> <p>Монгол Улсын Гаалийн ерөнхий газар Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их тойруу 81/1 Улаанбаатар 14193, Монгол улс</p>
ТООЗ 15.8 (б) (1)	Бараа хүргэгдэх нэрлэсэн газар эсхүл боомт: Улаанбаатар хот, Монгол Улс
ТООЗ 15.10	Гэрээний хэрэгжилтийн явцад тендерт оролцогчийн санал болгосон үнийг “тохируулахгүй, тогтмол байна.”
ТООЗ 17.1 (д)	Бараа нийлүүлэх тусгай зөвшөөрөл: “шаардлагагүй”
ТООЗ 18.1 (б)	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: “шаардлагатай”
ТООЗ 18.1 (в)	Засвар үйлчилгээ, техникийн тодорхойлолтод заасан сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үүргийг Монгол улсын нутаг дэвсгэрт өөрөө гүйцэтгэх, эсхүл төлөөлөгчөөрөө дамжуулан биелүүлэх тухай баримт нотолгоо: “шаардлагатай”
ТООЗ 20.1 (б)	Барааг тасралтгүй, горимын дагуу ашиглах, эсхүл ажиллуулахаар тооцоолж буй хугацаа: 5 жил
ТООЗ 21.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 90 хоногийн туршид хүчинтэй байна.
ТООЗ 22.1	Тендерийн баталгаа: “шаардлагатай”
	Хэрэв тендерийн баталгаа шаардлагатай бол уг тендерийн баталгааны үнийн дүн ба мөнгөн тэмдэгт: ₮30,000,000.00
ТООЗ 23.1	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: 1 хувь
	Эх хувийг флаш дээр хуулж софтоор мөн ирүүлэх шаардлагатай. Флаш диск дээр Тендерийн саналын эх хувийг хуулж битүүмжилнэ. Эх хувь, хуулбар хувь болон флаш хувийн хооронд зөрүү үүсвэл, эх хувийг баримтална.
	Г. Тендер ирүүлэх
ТООЗ 24.1	Тендерт оролцогч тендерийг цахим хэрэгслээр дамжуулан ирүүлэх “шаардлагагүй” .
ТООЗ 24.3 (б)	<p>Захиалагчийн хаяг (зөвхөн тендер хүлээн авах зорилгоор):</p> <p>Тендер хүлээн авах этгээд: Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн Н.Болороо</p> <p>Байгууллагын нэр: Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл</p> <p>Байгууллагын хаяг: МН Тауэр, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж-15141,</p> <p>Давхар ба өрөөний дугаар: 14 давхар, 1404 тоот өрөө</p> <p>Хот дүүрэг: Улаанбаатар</p> <p>Улс: Монгол улс</p>
ТООЗ 24.3 (в)	Тендерийн гаднах ба доторх дугтуйд ТООЗ 1.1-д заасан тендер шалгаруулалтын нэр ба дугаарыг гаргацтай тэмдэглэнэ.

ТӨӨЗ 24.6	Хэрэв тендерт оролцогч тендерийг цахим хэрэгслээр дамжуулан ирүүлэхээр бол тендерийг цахим хэрэгслээр дамжуулан ирүүлэх дараах горимыг баримтлана. <i>Хамаарахгүй</i>
ТӨӨЗ 25.1	Тендер ирүүлэх эцсийн хугацаа: Огноо: <i>2025 оны 2-р сарын 14-ний өдөр</i> Цаг: <i>Улаанбаатарын цагаар 15 цаг 00 минут</i>
	Д. Тендерийг нээх, үнэлэх
ТӨӨЗ 28.1	Тендер нээх газрын хаяг: Байгууллага: <i>Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх нэгж</i> Гудамж/байр: <i>МН Тауэр, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж-15141,</i> Давхар ба өрөөний дугаар: <i>14 давхар, 1404 тоот өрөө</i> Хот дүүрэг: <i>Улаанбаатар</i> Улс: <i>Монгол улс</i> Тендер нээх огноо ба цаг: Огноо: <i>2025 оны 2 дугаар сарын 14-ний өдөр</i> Цаг: <i>Улаанбаатарын цагаар 15 цаг 10 минут</i>
	Е. Гэрээ байгуулах эрх олгох
ТӨӨЗ 42.1	Барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хэмжээ: <i>10 хувь</i> Барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хэмжээ: <i>10 хувь</i>
ТӨӨЗ 43.2	Шалгарсан тендерт оролцогч гэрээний маягтыг хүлээн авсанаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа ажлын <i>14 хоногт</i> багтаан гэрээнд гарын үсэг зурж, захиалагчид хүргүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Гуравдугаар бүлгийн зорилго нь захиалагч тендерийг үнэлэх, мөн “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендерт оролцогчийн чадварыг дахин магадлахад ашиглах шалгуур үзүүлэлтийг тусгайлан тодорхойлоход оршино. Захиалагч нь эдгээр шалгуур үзүүлэлтийг боловсруулж, тендерийн баримт бичигт тусгана. Захиалагч энд заагаагүй аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.

Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт нь гэрээний баримт бичиг биш тул гэрээний салшгүй хэсэг болохгүй.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ЖАГСААЛТ

1. ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

1.1 Цар хүрээ

- 1.1.1 Дотоодын тээвэрлэлт ба бусад үйлчилгээ
- 1.1.2 Жижиг хэмжээний орхигдуулсан зүйлс эсхүл дутуу зүйлс

1.2 Олон багцтай гэрээ

1.3 Техникийн шалгуур үзүүлэлт

1.4 Эдийн засгийн шалгуур үзүүлэлт

- 1.4.1 Төлбөрийн нөхцлийн зөрүүг тохируулах
- 1.4.2 Хүргэх ба дуусгах хуваарийн зөрүүг тохируулах
- 1.4.3 Ашиглалтын ба засвар үйлчилгээний зардал
- 1.4.4 Сэлбэг хэрэгсэл
- 1.4.5 Барааны ашигт үйлийн коэффициент ба бүтээмж

2. ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- Эрх бүхий нөхцөл
- Жилийн дундаж борлуулалт
- Гэрээний туршлага
- Үйлдвэрлэлийн туршлага
- Санхүүгийн байдал
- Мөнгөн гүйлгээний чадавх
- Шүүхийн зарга ба маргаан

1. ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

1.1 Цар хүрээ

1.1.1 Дотоодын тээвэрлэлт ба бусад үйлчилгээ

Хэрэв захиалагч тус улсын нутаг дэвсгэрт барааг эцсийн цэгт хүргэхтэй холбоотойгоор нэмэгдэж гарах дотоодын тээвэрлэлт, даатгал болон бусад үйлчилгээний зардлыг тендерийн үнэлгээний явцад харгалзан үзэхээр бол,

Хамаарахгүй.

1.1.2 Жижиг хэмжээний орхигдуулсан зүйлс эсхүл дутуу зүйлс

Тендерийн үнэлгээг тэгш шударгаар явуулах нөхцлийг хангах үүднээс, нийлүүлэлт, үйлчилгээтэй холбоотой жижиг хэмжээний орхигдуулсан зүйлс эсхүл дутуу зүйлсийн зардлыг тендерийн үнэ дээр нэмж тооцно. Үнийн тохиргоог бусад шаардлага хангасан тендерүүдийн холбогдох үнийн саналыг харгалзан үзэж, хэрэгжүүлэгч агентлаг, инженер, зөвлөх эсхүл тендерийн үнэлгээний хорооны гаргасан зардлын зохих тооцоог үндэслэн хийнэ. Үнийн тохиргоог орхигдуулсан зүйлсийн бодит үнэд суурилна. Үнэ тогтооход ашиглагддаг хамгийн түгээмэл арга бол бусад тендерт оролцогчийн тухайн ижил нэр төрөлд тооцсон хамгийн өндөр үнийг ишлэн ашиглах явдал юм.

“ТООЗ-ны 33.3 дугаар зүйлд зааснаар, тоолж хэмжигдэх жижиг зөрүү эсхүл гэрээний болон арилжааны нөхцлүүдээс орхигдуулсан зүйлсийн зардлыг үнэлнэ. Захиалагч нь тендерийг шударгаар харьцуулах нөхцлийг хангах зорилгоор аливаа жижиг зөрүү ба орхигдуулсан зүйлсийн зардлын талаар өөрийн гэсэн үнэлгээг хийнэ.”

1.2 Олон багцтай гэрээ

Хэрэв бараа ба холбогдох үйлчилгээг хэд хэдэн багцад бүлэглэн хуваасан бол дараах заалтыг ашиглана.

Хамаарахгүй.

1.3 Техникийн шалгуур үзүүлэлт

Бараа ба холбогдох үйлчилгээ нь Зургаадугаар бүлэг буюу “Нийлүүлэх хуваарь”-ийн шаардлагыг хангасан байх ёстой тул техникийн шалгуур үзүүлэлт бүрт шаардагдах техникийн хамгийн доод түвшинг тодорхойлж өгнө. Боломжтой бол, шалгуур бүрт хамгийн доод түвшинг тогтоохдоо “тэнцсэн эсхүл тэнцээгүй” зарчмыг ашиглан, техникийн шалгуур үзүүлэлтийг үнэлнэ.

Гэхдээ, техникийн шаардлагад нийцээгүй жижиг зөрүү нь тендерээс татгалзах шалтгаан болох ёсгүй. Ийм үл ялих зөрүүнд тухайлбал, шаардсанаас бага хүчин чадалтай нэмэлт хөдөлгүүр эсхүл тээврийн хэрэгслийн шулуун хээтэй дугуйны оронд огтлолцсон хээтэй дугуйг нийлүүлэх санал зэрэг орно. Аливаа зөрүүг засаж сайжруулахтай холбогдон гарах зардлыг тухайн тендерийн үнэ дээр нэмж тооцно. Үл нийцэж буй зүйл эсхүл бүрэлдэхүүн хэсэгт хамгийн түгээмэл хэрэглэгддэг аргачлал гэвэл, дээр өгүүлсэн “Цар хүрээ”-ний шалгуур үзүүлэлттэй ижил аргачлалыг баримтлан хасагдсан зүйл ба бүрэлдэхүүн хэсгийн үнийг нэмж оруулах байдлаар үнийг тогтоох явдал юм.

Зургаадугаар бүлэг буюу “Нийлүүлэх хуваарь”-т заасан техникийн шаардлагаас өөр аливаа тоолж хэмжигдэхүйц шинжтэй зөрүүний зардлыг тооцож үнэлнэ. Захиалагч нь тендерийг шударгаар үнэлж харьцуулах нөхцлийг хангах зорилгоор тэдгээр зөрүүнд ногдох зардлын талаар өөрийн гэсэн үнэлгээг хийнэ.”

1.4 Эдийн засгийн шалгуур үзүүлэлт

Эдийн засгийн шалгуур үзүүлэлтүүд нь тендерийг үнэлэхэд нэн чухал ач холбогдолтой. Ихэнх тохиолдолд эдгээр шалгуур үзүүлэлтийг зөвхөн техникийн үнэлгээнд тэнцсэн тендерийг үнэлэхэд ашигладаг. Мөнгөөр илэрхийлж болох өөр шалгуур үзүүлэлтүүд байдаг тул үнэ нь цорын ганц шалгуур үзүүлэлт биш юм. Эрчим хүчээр ажилладаг төхөөрөмж ба хэрэгслийн хувьд үнэлэгдсэн тендерийн үнийг тооцохдоо техникийн тодорхойлолтод дурдсан үйл ажиллагааны баталгаат хэмжээнээс давсан үр ашиг (цахилгаан үүсгүүр, насос), алдагдал (трансформатор) болон төхөөрөмжийн ирээдүйн ашиглалтын зардал зэрэгт шаардагдах тохиргоог харгалзан үзэж болно. Үйл ажиллагааны баталгаа ба ирээдүйн ашиглалтын зардал нь тендерийн үнэлгээнд хүчин зүйл болно хэмээн зөвхөн тендерийн баримт бичигт заасан үед ийм тохиргооны (тухайн тохиолдлоос хамаарч тендерийн үнэ дээр нэмэх эсхүл хасах) санхүүгийн өртөг зардлыг тооцно. Үнэлгээний эдгээр хүчин зүйлсийг тооцох аргачлалыг тендерийн баримт бичигт тусгайлан тодорхой заана. Өртөг зардлыг тооцох арга нь дээр дурдсанаас ангид зөрүүтэй бол түүнийг хэрэглэхгүй болно.

Эдгээр шалгуур үзүүлэлтийн жишээг доор дурдсанаас үзэж болно:

1.4.1 Төлбөрийн нөхцлийн зөрүүг тохируулах

Захиалагч нь ГТН-ийн 15.1-д тодорхойлсон төлбөрийн нөхцлийн зөрүүг ашиглах эсхүл эс ашиглах эсэхийг энд заана. Хэрэв ашиглах бол, захиалагч нь төлбөрийн нөхцлийн зөрүүг дараах аргаар үнэлнэ. Захиалагч юуны өмнө ГТН-ийн 15.1-д заасан төлбөрийн нөхцлийг ашиглан тендерүүдийг үнэлнэ. Дараа нь зөрүүг тооцсоны дагуу тендерийн үнэ дээр зохих тохиргоог нэмнэ. Уг тохиргоог тооцохдоо санал болгосон төлбөрийг захиалагчийн анх шаардсан төлбөрийн нөхцөлтэй харьцуулах замаар бууруулна.

“ГТН-ийн 15.1-д дурдсан төлбөрийн нөхцлийн зөрүүг ашиглахгүй.”

1.4.2 Хүргэх ба дуусгах хуваарийн зөрүүг тохируулах

Тендерг оролцогч нь Зургаадугаар бүлэг буюу “Нийлүүлэх хуваарь”-ийн хүргэх ба дуусгах хуваарьт үндэслэн тендерийн үнийг тогтоох шаардлагатай. Захиалагч нь хүргэх ба дуусгах хуваариас ялгаатай зөрүүг ашиглах эсхүл эс ашиглах эсэхийг энд заана. Хэрэв ашиглах бол, захиалагч нь доор дурдсан горимын дагуу холбогдох үнийн тохиргоог нэмж тооцох байдлаар хүргэлтийг үнэлнэ.

Зургаадугаар бүлэг буюу “Нийлүүлэх хуваарь”-ийн хүргэх ба дуусгах хуваарийн зөрүүг ашиглахгүй.

1.4.3 Ашиглалтын ба засвар үйлчилгээний зардал

Барааны эдэлгээний явцад гарах ашиглалтын ба засвар үйлчилгээний зардал нь тухайн барааны капиталын (үндсэн хөрөнгийн) эсхүл хөрөнгө оруулалтын зардалд хамаарах гол зардлыг илэрхийлэх бол ийм зардлыг тендерийн үнэлгээнд харгалзан үзнэ. Барааны капиталын зардал болон ашиглалт, засвар үйлчилгээний зардлын хэмжээ нь технологийн шийдлээс хамааран харилцан адилгүй байдаг. Барааг үйлдвэрлэх явцад маш нарийн технологи, материал ашигласан бол хөрөнгө оруулалтын зардал ихээр өсч, ашиглалтын ба засвар үйлчилгээний зардал буурдаг. Ашиглалтын ба засвар үйлчилгээний зардлыг барааны эдэлгээний үеийн өнөөгийн үнээр үнэлэх ба барааны үнэ дээр нэмж тооцно.

Хамаарахгүй

1.4.4 Сэлбэг хэрэгсэл

Тендерийн үнэлгээнд зөвхөн Зургаадугаар бүлэг буюу “Нийлүүлэх хуваарь”-ийн бараа ба холбогдох үйлчилгээний жагсаалтанд нэр төрлөөр тусгагдсан сэлбэг хэрэгслийг харгалзан үзнэ. Ашиглалтын тусгай шаардлагын үүднээс нийлүүлэгчээс санал болгосон сэлбэг хэрэгслийг тендерийн үнэлгээнд харгалзан үзэхгүй.

Хамаарахгүй

1.4.5 Барааны ашигт үйлийн коэффициент ба бүтээмж

Барааны ашигт үйлийн коэффициент эсхүл бүтээмжтэй хамаарах тохируулгын хүчин зүйлийг тооцохдоо Зургаадугаар бүлэг буюу “Нийлүүлэх хуваарь”-т заасан норм үзүүлэлт (өөрөөр хэлбэл, үр ашиг) ба тендерийн саналд тендерт оролцогчийн баталгаажуулсан холбогдох үзүүлэлтийн хоорондын зөрүүг үндэслэнэ. Тооцоог дараах аргаар хийнэ:

Хамаарахгүй.

2. ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Энгийн, хүрэлцээтэй, бэлэн барааг худалдан авахад техникийн тодорхойлолтод нийцсэн эсэх, мөн тухайн тоног төхөөрөмж эсхүл машин механизм нь хэрэглээнд бодитойгоор, хангалттай соригдож туршигдсан эсэхийг тогтоохоос бусад үед тендерт оролцогчийн чадварыг нарийн шалгах шаардлагагүй байж болно.

Хэрэв “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерт оролцогч гэрээгээр хүлээсэн үүргийг хангалттай хэмжээнд гүйцэтгэх чадвартай эсэхийг нягтлан тогтоох шаардлагатай бол, тухайлбал, чадварын урьдчилсан сонголт явуулах нь зохимжгүйд тооцогдсон өндөр үнэтэй, техникийн хувьд маш нарийн бүрдэлтэй үйлдвэр байгууламж, тоног төхөөрөмж, машин механизмыг худалдан авахтай холбоотойгоор, захиалагч нь зохих чадварын шалгуур үзүүлэлтүүдийг энэ хэсэгт тусгайлан тогтоож болно.

Тухайн худалдан авах ажиллагааны мөн чанараас шалтгаалан, хөрөнгө мөнгө, цаг хугацааны хүчин зүйлийг харгалзан үзэх замаар тендерт оролцогчдын гэрээг гүйцэтгэхэд шаардагдах санхүү, техник, үйлдвэрлэл, худалдан авалт, тээвэрлэлт, угсралт ба бусад чадавх зэрэг чухал асуудалтай холбогдолтой чадваруудыг үнэлэх шаардлага гарч болно. Тендерт оролцогчийн гэрээг амжилттай хэрэгжүүлэх чадварыг тодорхойлоход зайлшгүй шаардагдах тэдгээр мэдээллийг шаардан авах ёстой. Эдгээр шалгуур үзүүлэлтийг зөвхөн “тэнцсэн эсхүл тэнцээгүй” зарчмын дагуу үнэлнэ. Харьцуулж болохуйц техникийн үзүүлэлттэй бараа, холбогдох үйлчилгээг нийлүүлэх талаарх тендерт оролцогчийн туршлага, үйлдвэрлэх ба угсрах чадавх, санхүүгийн чадавх, бусад хүчин зүйлсийн хамгийн доод түвшинг тодорхойлох шаардлагатай.

Тендерт оролцогчийн нэг буюу хэд хэдэн чухал чадварыг тогтоох зорилгоор дор дурдсан шалгуур үзүүлэлтүүдийг дангаар нь эсхүл хамтад нь хэрэглэж болно:

Эрх бүхий нөхцөл

Улсын харьяалал, сонирхлын зөрчил, төрийн өмчит аж ахуйн нэгжийн байдал болон АХБ ба олон улсын хөгжлийн бусад байгууллагын хориг гэх зэргээр тендерт оролцогчийн эрх бүхий нөхцөл

Жилийн дундаж борлуулалт

Сүүлийн 3 /2022, 2023, 2024/ жилд гүйцэтгэж дууссан эсхүл гүйцэтгэж байгаа гэрээний жилийн дундаж борлуулалтын доод хэмжээ ₮2.9 тэрбум төгрөг байна. Энэ хэмжээг тендерт оролцогчийн сүүлийн гурван жилд гүйцэтгэж дууссан эсхүл гүйцэтгэж буй гэрээний хүрээнд хийгдсэн нийт төлбөрийн хэмжээгээр тодорхойлно.

Гэрээний туршлага

Сүүлийн 3 жилд үндсэн гүйцэтгэгчээр амжилттай ажиллаж дуусгасан хоёр гэрээтэй байна. Гэрээний үнийн дундаж хэмжээ нь ₮2.3 тэрбум төгрөгөөс доошгүй байна. Гэрээний агуулга ба иж бүрдэл нь нэрлэсэн тендертэй ижил байна.

Санхүүгийн байдал

Сүүлийн 3 жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан (тайлан баланс, орлогын тайлан)-г үндэслэн тендерт оролцогч урт хугацаанд ашигтай ажиллаж байгааг харуулж чадах санхүүгийн тогтвортой байдал.

Мөнгөн гүйлгээний чадавх

Гэрээний хэрэгжилтийн явцад шаардлагатай мөнгөн гүйлгээний хэрэгцээг хангаж чадах түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, авах боломжтой зээл, эсхүл бусад санхүүжилтийн нийт хэмжээ.

Шүүхийн зарга ба маргаан

Одоо хянан шийдвэрлэгдэж буй аливаа нэхэмжлэл, шаардлага, арбитрын ажиллагаа, эсхүл бусад төрлийн шүүхийн зарга, маргааны нийт хэмжээ нь тендерт оролцогчийн цэвэр хөрөнгийн **50** хувиас илүүгүй байна.

Жич: Сүүлийн 3 жилд 2022, 2023, 2024 онууд хамаарна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН МАЯГТ

Тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагын дагуу тендер шалгаруулалтын бүх маягтыг бүрэн бөглөж, тендерийн саналд тусгаж ирүүлнэ.

- Тендер ирүүлэх маягт
- Үнийн хуваарь
- Тендерийн баталгаа
- Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл
- Чадварын мэдээлэл ирүүлэх маягт
 - ✓ Тендерт оролцогчийн мэдээллийн маягт
 - ✓ Түншлэлийн мэдээллийн маягт
 - ✓ Шүүхийн зарга болон арбитрын маргаан
 - ✓ Санал болгож буй туслан гүйцэтгэгч
 - ✓ Ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага
 - ✓ Одоо хэрэгжиж буй гэрээний мэдээлэл
 - ✓ Санхүүгийн чадавх
 - ✓ Санхүүгийн нөөц хөрөнгийн хүртээмж
 - ✓ Ажиллах хүчний чадавх

ТЕНДЕР ИРҮҮЛЭХ МАЯГТ

Огноо: [тендер ирүүлсэн (өдөр, сар, он)]
ДӨТШ-ын дугаар: [оруул:тендер шалгаруулалтын дугаар]
Хувилбарын дугаар: [энэ нь хувилбарт тендер бол ялгах дугаар оруулах. Хэрэв хувилбарт тендерийг зөвшөөрөхгүй бол энэ хэсгийг хасах]

(Захиалагчийн нэр)-ын дарга _____ Танаа,

1. Бид энэхүү тендерийн баримт бичиг, түүний өөрчлөлттэй танилцсан бөгөөд ямар нэгэн болзолт нөхцөлгүй гэдгээ үүгээр илэрхийлэн мэдэгдэж байна.
2. Бид энэхүү тендерийн баримт бичигт нийцүүлэн, техникийн тодорхойлолт ба бусад шаардлагад заасан хүргэх хуваарийн дагуу доор дурдсан бараа ба холбогдох үйлчилгээг нийлүүлэхээр санал болгож байна. Үүнд:
-
-
-
3. Тендерийн нийт үнэ [тендерийн үнийг тоогоор болон үсгээр оруул] төгрөг байх бөгөөд үүнд доорх 4 дүгээр заалтанд санал болгосон аливаа хөнгөлөлтүүд хамаарахгүй.
4. Бид дараах үнийн хөнгөлөлт үзүүлэх ба түүнийг тооцохдоо доор дурдсан аргачлалыг хэрэглэхийг санал болгож байна: _____
5. Бидний тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
6. Бидний тендер шалгарсан тохиолдолд гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулж гэрээний үнийн дүнгийн хувьтай тэнцэх гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхээ амлаж байна.
7. Манай компани болон гэрээний аль нэг хэсгийг гүйцэтгэх туслан гүйцэтгэгч эсхүл нийлүүлэгч нь Азийн Хөгжлийн Банкны эрх бүхий дараах улсын харьяат юм:
_____.
8. Энэхүү тендер шалгаруулалтад бид тендерт оролцогчийн хувьд нэгээс дээш тендер (тендерийн баримт бичигт зөвшөөрсөн бол хувилбарт тендерээс бусад тендер) ирүүлээгүй болно.
9. Манай компани, түүний салбар эсхүл төлөөлөгчийн газар болон гэрээний аль нэг хэсгийг гүйцэтгэх туслан гүйцэтгэгч эсхүл нийлүүлэгч нь АХБ-наас эрх бүхий бус гэж зарлагдаагүй болно.
10. Бид төрийн өмчит байгууллага биш болно/Бид төрийн өмчит байгууллага мөн боловч ТООЗ-ны 4.4-т заасан шаардлагыг хангасан болно. [Тэмдэглэл: Энэ хоёр хувилбарын аль тохирохыг хэрэглэх]
11. Энэхүү тендер шалгаруулалт эсхүл гэрээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан бид доор дурдсан шимтгэл, шан харамж, эсхүл хураамжийг төлсөн эсхүл төлөх болно:

Хүлээн авсан хүний нэр:

Хаяг:

Шалтгаан:

Хэмжээ:

(Хэрэв ямар нэгэн төлбөр хийгээгүй эсхүл хийгдэхгүй бол “үгүй” гэж оруулах)

12. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер, мөн зөвшөөрсөн тухай танай захидал болон гэрээ байгуулах эрх олгох танай мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн заавал дагаж мөрдөх гэрээ байх болно гэдгийг бид ухамсарлан ойлгож байна.
13. Тендер шалгаруулалтад “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер болон бусад тендерийг та бүхэн зайлшгүй хүлээн зөвшөөрөх үүрэг хүлээхгүй гэдгийг бид ойлгож байна.
14. Азийн Хөгжлийн Банк болон түүний төлөөлөгч бидний ирүүлсэн тендертэй холбоотойгоор манай данс, бүртгэл тооцоо болон бусад баримт бичгийг шалгах, тус банкнаас томилогдсон аудитор тэдгээрт аудит хийхийг зөвшөөрч байна.

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга: _____

Нэр ба албан тушаал: _____

Тендерг оролцогчийн нэр: _____

Хаяг: _____

Огноо: _____

**МОНГОЛ УЛСАД ҮЙЛДВЭРЛЭГДСЭН
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**
(А ангилал)

ТШ-ын дугаар: _____
Хувилбарт тендерийн дугаар: _____

ТООЗ-ны 16-д заасан мөнгөн тэмдэгтээр

1	2	3	4	5	6	7	8
Дугаар	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг	EXW нэгж үнэ	Нэр төрөл бүрийн EXW нийт үнэ (4x5)	ТООЗ-ны 15.8(а).(2)-д заасан гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨАТ болон бусад татвар хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (5+7)
Нийт үнэ							

Тендерт оролцогчийн нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____

**МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРЖ ИРЭХ
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**
(Б ангилал)

ТШ-ын дугаар: _____
Хувилбарт тендерийн дугаар: _____

ТООЗ-ны 16-д заасан мөнгөн тэмдэгтээр

1	2	3	4	5	6	7	8
Дугаар	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг	ТООЗ-ны 15.8 (б) (1)-д заасан СИФ эсхүл СИП нэгж үнэ	Нэр төрөл бүрийн СИФ эсхүл СИП нийт үнэ (4x5)	ТООЗ-ны 15.8(б).(2)-д зааснаар гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨАТ болон бусад татвар хураамж	Нэр төрлийн нийт дүн (6+7)
Нийт үнэ							

Тендерт оролцогчийн нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____

**МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ӨМНӨ НЬ ИМПОРТООР ОРУУЛЖ ИРСЭН
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**

(В ангилал)

ТШ-ын дугаар: _____
Хувилбарт тендерийн дугаар: _____

ТӨӨЗ-ны 16-д заасан мөнгөн тэмдэгтээр

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Дугаар	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Инкотерм-т тусгасны дагуу хүргэх огноо	Тоо ширхэг	ТӨӨЗ-ны 15.8 (в) (1)-д заасан урьд нь төлсөн болон гаалийн татвар, хураамж болон импортын татварыг оруулсан нэгж үнэ	ТӨӨЗ-ны 15.8(в).(2)-д заасан нэр төрөл бүрт төлсөн гаалийн болон импортын татвар, хураамж [нотлох бичиг баримтыг үндэслэнэ]	ТӨӨЗ-ны 15.8 (в) (3)-д заасны дагуу нэгж үнэ (гаалийн татвар, хураамж болон импортын татварыг хассан) (6 – 7)	ТӨӨЗ-ны 15.8 (в) (3) (9=8x5)-д заасны дагуу гаалийн болон импортын татварыг хассан нэр төрөл бүрийн нийт үнэ	Гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨАТ болон бусад татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (9+10)
Нийт үнэ										

Тендерт оролцогчийн нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____

САНАЛ БОЛГОЖ БУЙ ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ХУВААРЬ

Дугаар:
Хувилбарт тендерийн дугаар:

ТООЗ-ны 16-д заасан мөнгөн тэмдэгтээр

1	2	3	4	5	6	7
Дугаар	Үйлчилгээний тодорхойлолт	Гарал үүслийн улс	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн нийт үнэ
Нийт үнэ						

Тендерт оролцогчийн нэр

Гарын үсэг

Огноо

ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

Захиалагч:

Огноо:

БАНКНЫ БАТАЛГАА №

..... [Тендерт оролцогчийн нэрийг оруулах] (цаашид “тендерт оролцогч” гэх) нь
[тендер шалгаруулалтын нэрийг оруулах] бараа нийлүүлэхээр тендер (цаашид “тендер” гэх) санал
болгосонтой холбогдуулан,

Энэхүү баталгаагаар [банкны нэрийг оруулах] (цаашид “банк” гэх) нь
[захиалагчийн нэрийг оруулах] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт [мөнгөн дүнг тоогоор
оруулах]-ийн¹ төлбөр хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь доор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

- (1) тендерт оролцогч Тендер ирүүлэх маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерийг буцааж авсан;
- (2) захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
 - (а) Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;
 - (б) Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;
 - (в) Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн арифметикийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.

Энд тодорхойлогдсон нөхцлүүдийн аль нэг нь үүсээнийг дурдаж дээр зааснаас хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй төлбөрийг үл маргалдах журмаар хийнэ.

Энэхүү баталгаа нь [огноог оруул]² өдрийг дуустал хүчинтэй байна. Захиалагч энэ баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж банкинд мэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Гарын үсэг ба тамга:

Банкны эрх бүхий ажилтны нэр ба албан тушаал:

Огноо:

Хаяг:

¹ Тендерийн баталгааны дүнг төгрөгөөр илэрхийлнэ. Тендерийн баталгааны мөнгөн дүн нь ТООЗ-ны 22.1-д заасантай ижил байна.

² Тендерийн баталгааны хүчинтэй байх огноог оруулахдаа ТООЗ-ны 22.1-д заасны дагуу тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног байхаар тооцно.

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ

[Тайлбар: Энд дурдсан зааврын дагуу үйлдвэрлэгч энэ маягтыг бөглөнө. Энэхүү зөвшөөрлийг үйлдвэрлэгчийн албан бланк дээр бичиж, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байна. ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерг оролцогч үүнийг тендерийн хамт ирүүлнэ.]

Огноо: *[тендер ирүүлсэн (өдөр, сар, он)]*

ДӨТШ-ын дугаар: *[оруул: тендер шалгаруулалтын дугаар]*

Хувилбарын дугаар: *[оруул: энэ нь хувилбарт тендер бол ялгах дугаар]*

(Захиалагчийн нэр)-ын дарга _____ Танаа

Бид, *[үйлдвэрлэгчийн бүтэн хаягийг оруулах]*-д байршилтай *[үйлдвэрлэгчийн бүрэн нэрийг оруулах]* нь *[үйлдвэрлэдэг/борлуулдаг барааны төрлийг оруулах]*-ийг албан ёсоор үйлдвэрлэдэг/борлуулдаг бөгөөд үүгээр *[тендерг оролцогчийн бүтэн нэрийг оруулах]* компанид бидний үйлдвэрлэсэн/борлуулсан *[оруул: барааны нэр ба товч тодорхойлолт]* барааг санал болгосон тендер ирүүлж, улмаар хэлэлцээр хийж гэрээ байгуулахыг зөвшөөрч байна.

Бид дээр дурдсан компанийн санал болгосон барааны хувьд гэрээний ерөнхий нөхцлийн 14-т заасны дагуу чанарын баталгааг бүрэн гаргаж байна.

Үйлдвэрлэгчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Нэр ба албан тушаал:

Гарын үсэг зурсан огноо:

Хаяг:

ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ

Гуравдугаар бүлэг (Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт)-т нийцүүлэн гэрээ хэрэгжүүлэх чадвартай болохоо нотлох зорилгоор тендерт оролцогч нь энд тусгагдсан холбогдох мэдээллийн маягтуудыг ашиглан шаардагдах мэдээллийг гаргаж өгнө.

ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ

ЭРХ-1 Маягт: Тендерт оролцогчийн мэдээллийн маягт

Тендерт оролцогчийн талаарх мэдээлэл	
Тендерт оролцогчийн албан ёсны нэр	
Түншлэлийн хувьд, гишүүн тус бүрийн албан ёсны нэр	
Үүсгэн байгуулагдсан улс	
Байгуулагдсан он	
Үүсгэн байгуулагдсан улс дахь тендерт оролцогчийн албан ёсны хаяг	
Тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч (нэр, хаяг, холбогдох утас, факс, цахим шуудангийн хаяг)	
<p>Дараах баримт бичгүүдийн хуулбарыг хавсаргав:</p> <p><input type="checkbox"/> 1. Дангаар оролцогч этгээдийн хувьд, ТООЗ-ны 4.1-т заасны дагуу дээр нэр дурдагдсан хуулийн этгээдийн үүсгэн байгуулсан баримт.</p> <p><input type="checkbox"/> 2. ТООЗ-ны 17.1(г)-т заасны дагуу, дээр нэр дурдагдсан этгээд эсхүл түншлэлийг төлөөлөх эрхийн зөвшөөрөл.</p> <p><input type="checkbox"/> 3. Түншлэлийн хувьд, ТООЗ-ны 6.1(б)-т заасны дагуу түншлэл байгуулах тухай албан тоот эсхүл түншлэлийн гэрээ.</p> <p><input type="checkbox"/> 4. Төрийн өмчит байгууллагын хувьд, ТООЗ-ны 4.4-т заасны дагуу энэхүү хэсгийн 1-р мөрөнд тодорхойлноос өөр бусад нэмэлт баримт бичгүүд.</p>	

ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ

ЭРХ-2 Маягт: Түншлэлийн мэдээллийн маягт

Түншлэлийн гишүүн тус бүр, мөн туслан гүйцэтгэгч нар нь энэхүү маягтыг бөглөнө.

Түншлэл / туслан гүйцэтгэгчийн мэдээлэл	
Тендерт оролцогчийн албан ёсны нэр	
Түншлэлийн гишүүн эсхүл туслан гүйцэтгэгчийн албан ёсны нэр	
Үүсгэн байгуулагдсан улс	
Байгуулагдсан он	
Үүсгэн байгуулагдсан улс дахь түншлэлийн гишүүн эсхүл туслан гүйцэтгэгчийн албан ёсны хаяг	
Түншлэлийн гишүүн эсхүл туслан гүйцэтгэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлэл (нэр, хаяг, холбогдох утас, факс, цахим шуудангийн хаяг)	
<p>Дараах баримт бичгүүдийн хуулбарыг хавсаргав:</p> <p><input type="checkbox"/> 1. ТООЗ-ны 4.1-т заасны дагуу, дээр нэр дурдагдсан хуулийн этгээдийн үүсгэн байгуулсан баримт.</p> <p><input type="checkbox"/> 2. ТООЗ-ны 17.1(г)-т заасны дагуу, дээр нэр дурдагдсан этгээдийг төлөөлөх эрхийн зөвшөөрөл.</p> <p><input type="checkbox"/> 3. Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд, ТООЗ-ны 4.4-т заасны дагуу эрх зүйн болон санхүүгийн хувьд бие даасан, мөн аж ахуйн нэгжийн хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа болохыг нотлох баримт бичгүүд.</p>	

Туслан гүйцэтгэгч гэдэгт үндсэн гүйцэтгэгчийн хийж чадахгүй, нарийн мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэн явуулдаг мэргэшсэн аж ахуйн нэгжийг хамааруулан ойлгоно.

ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ

МАРГ-1 Маяг: Шүүхийн зарга ба арбитрын маргаан

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүн тус бүр хэрэв Гуравдугаар бүлэг (Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт)-т шаардсан тохиолдолд энэхүү маягтыг бөглөнө.

Түншлэлийн гишүүн: _____

Шүүхийн зарга ба арбитрын маргаан			
Дараах хариултаас аль тохирохыг сонго: <input type="checkbox"/> Шүүхэд хянагдаж буй зарга нэхэмжлэл, арбитрын маргаан байхгүй. <input type="checkbox"/> Тендерт оролцогчид (эсхүл, хэрэв тендерт оролцогч нь түншлэл бол, түншлэлийн гишүүн бүрт) хамааралтай шүүхэд хянагдаж буй аливаа зарга нэхэмжлэл, арбитрын маргааны мэдээллийг доор тусгав.			
Он	Зарга маргаан	Хянагдаж буй нэхэмжлэлийн хэмжээ, төгрөгөөр	Хянагдаж буй нэхэмжлэлийн хэмжээ, цэвэр хөрөнгөтэй харьцуулсан хувиар
Дараах баримт бичгүүдийн хуулбарыг хавсаргав: <input type="checkbox"/> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас шүүхийн маргаантай талаарх тодорхойлолт			

ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ

САНАЛ БОЛГОЖ БУЙ ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ

№	Бараа ба холбогдох үйлчилгээний нэр	Туслан гүйцэтгэгчийн нэр	Бүртгэгдсэн газар болон чадавх

ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ

ИЖИЛ ТӨРЛИЙН ГЭРЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН ТУРШЛАГА

[Тайлбар: Энэ маягтыг зөвхөн Гуравдугаар бүлэг буюу “Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт”-д заасан шаардлагыг хангасан гэрээ бүрт бөглөнө.]

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр:

1.	Гэрээний дугаар	
2.	Гэрээний нэр	
3.	Улсын нэр	
4.	Захиалагчийн нэр	
5.	Захиалагчийн хаяг	
6.	ТББ-д тодорхойлсон гэрээтэй холбогдох ижил төрлийн болон бусад онцлог	
7.	Гэрээнд оролцсон байдал (зөвхөн нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн	
8.	Гэрээ /туслан гүйцэтгэх эсхүл түншлэлд ногдох гэрээний хэмжээ: төгрөг (гэрээнд гарын үсэг зурсан өдрийн ханшаар)	
9.	Гэрээний дүн: Туслан гүйцэтгэх гэрээний дүн: Түншлэлийн хувьд ногдох гэрээний дүн:	
10.	Гэрээг эхэлсэн огноо:	
11.	Гэрээг хэрэгжүүлж дууссан огноо: (хэрэв тогтоосон хугацаанаас хоцорсон бол тайлбар оруулах)	
12.	Гэрээний дагуу хийгдсэн төлбөрийн дүн: (хэрэв үндсэн дүнгээс хэтэрсэн бол тайлбарлах)	

ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ

ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

[Тайлбар: Энэ маягтыг зөвхөн Гуравдугаар бүлэг буюу “Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт”-д заасан шаардлагыг хангасан гэрээ бүрт бөглөнө. Одоо хэрэгжиж байгаа гэрээ гэдгийг амжилттай хэрэгжиж дууссан гэрээ гэж тодорхойлон үзэж болохгүй.]

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр:

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, холбоо барих хаяг, утас, факс	Гэрээний үнийн дүн	Гэрээг дуусгахаар төлөвлөсөн хугацаа	Дараагийн 6 сард нэхэмжлэн авах үнийн дүнгийн сарын дундаж хэмжээ
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад				

ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ

САНХҮҮГИЙН ЧАДАВХ

[Тайлбар: Энэ маягтыг зөвхөн Гуравдугаар бүлэг буюу “Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт”-д заасан шаардлагыг хангасан бол бөглөнө.]

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр:

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр Гуравдугаар бүлэг буюу “Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт”-д тодорхойлсон холбогдох шаардлагыг хангаж буйг харуулсан санхүүгийн холбогдох мэдээллийг энэ маягтын дагуу ирүүлнэ. Шаардлагатай бол банкны мэдээллийн хүснэгтийг тус тусдаа бөглөнө. Татварын албанд тушаасан (захиалагч шаардсан бол аудитаар баталгаажуулсан байх) санхүүгийн тайланг нотлох баримт болгон энд хавсаргана.

Банкны нэр:	
Банкны хаяг:	
Утас:	Холбоо барих ажилтны нэр:
Факс:	Албан тушаал:

Сүүлийн (тоо оруул) жилийн хугацааны нийт хөрөнгө болон эх үүсвэрийг төгрөгөөр (хөрвүүлэх ханш нь тухайн жил бүрийн эцсийн байдлаар мөрдөгдөж байсан Монголбанкны зарласан ханш байна) илэрхийлнэ.

Санхүүгийн мэдээлэл /сая төгрөг/	Сүүлийн (тоо оруул) хүртэлх жилийн хугацаанд					Ирэх 2 жилийн төлөв	
	1	2	3	4	5	1	2
1. Нийт хөрөнгө							
2. Эргэлтийн хөрөнгө							
3. Нийт өр төлбөр							
4. Богино хугацааны өр төлбөр							
5. Татварын өмнөх ашиг							
6. Татварын дараах ашиг							

Санал болгож буй санхүүгийн эх үүсвэр буюу Гуравдугаар бүлэгт холбогдох шаардлагыг ханган гэрээг гүйцэтгэх явцад хүрэлцэхүйц эргэлтийн хөрөнгийн эх үүсвэртэйг харуулсан түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, авах боломжтой зээл буюу зээлжих баталгаажсан эрх болон бусад санхүүгийн хэрэгслийг тодорхойлно.

Эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад эх үүсвэр	Дүн
1.	
2.	
3.	
4.	

Гуравдугаар бүлэгт заасан хугацааны (тендер оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр) аудитын компаниар хянагдаж баталгаажсан санхүүгийн тайлан, түүнд хийсэн тайлбарыг хавсаргана.

Хэрэв тендерт оролцогчийн улсын хуулиар аудитын баталгааг шаарддаггүй бол хувийн байгууллагын санхүүгийн тайланг эрх бүхий бүртгэгдсэн нягтлан бодогч болон татварын байгууллагын тодорхойлолтын хуулбарыг хавсаргана.

ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ

САНХ-3 Маягт: Санхүүгийн нөөц хөрөнгийн хүртээмж

Гуравдугаар бүлэг буюу “Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт”-д заасан Санхүүгийн нөөц хөрөнгийн шаардлагыг хангахад хүрэлцэх түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, зээлийн шугам, мөн бусад санхүүжилтийн нөөц хөрөнгө (гэрээний урьдчилгаа төлбөр үүнд хамаарахгүй) гэх зэрэг санхүүгийн эх үүсвэрүүдийг дурдана.

Санхүүгийн эх үүсвэр		
№	Санхүүжилтийн эх үүсвэр	Мөнгөн дүн (төгрөгөөр)
1		
2		
3		

ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЧАДАВХ

Тендерт оролцогч нь гэрээний удирдлага болон хэрэгжилтийг хариуцан ажиллахтай холбогдох ур чадвар, мэргэжлийн шаардлагыг хангасан ажилтны нэрийг албан тушаал тус бүрт дэвшүүлнэ. Нэр дэвшигч бүрийн ажлын туршлагын талаарх мэдээллийг тусад нь гаргаж ирүүлнэ.

1	Албан тушаал:
	Нэр:
2	Албан тушаал:
	Нэр:
3	Албан тушаал:
	Нэр:
4	Албан тушаал:
	Нэр:

ТАВДУГААР БҮЛЭГ. ЭРХ БҮХИЙ ОРНУУД

Бүсийн гишүүн орнууд		Бүсийн бус гишүүн орнууд
Афганистан	Монгол	Австри
Армен	Мянмар	Бельги
Авсрали	Науру	Канад
Азербайжан	Непаль	Дани
Бангладеш	Шинэ Зеланд	Финлянд
Бутан	Ниуэ	Франц
Бруней Даруссалам	Пакистан	Герман
Камбож	Палау	Ирланд
БНХАУ	Папуа Шинэ Гвиней	Израиль
Күүкийн арлууд	Филиппин	Итали
Фижи	Самоа	Люксембург
Гүрж	Сингапур	Нидерланд
Хонг Конг, Хятад	Соломоны арлууд	Норвеги
Энэтхэг	Шри Ланка	Португал
Индонез	Тайпэй, Хятад	Испани
Япон	Тажикстан	Швед
Казахстан	Тайланд	Швейцарь
Кирибати	Тимор-Лесте	Турк
БНСУ	Тонга	ИБУИНВУ
Киргиз	Туркменстан	АНУ
Лаос	Тувалу	
Малайз	Узбекстан	
Малдив	Вануату	
Маршлын арлууд	Вьетнам	
Микронезийн холбооны улс		

ХОЁРДУГААР ХЭСЭГ – БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ

Нийлүүлэх хуваарь нь дөрвөн хэсгээс бүрдэнэ:

1. Барааны жагсаалт ба хүргэх хуваарь
2. Холбогдох үйлчилгээний жагсаалт ба дуусгах хуваарь
3. Техникийн тодорхойлолт

1. БАРААНЫ ЖАГСААЛТ БА ХҮРГЭХ ХУВААРЬ

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө].

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермс-ийн нөхцлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа хүргэх хамгийн эхний хугацаа	Бараа хүргэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
[Дугаар бичих]	[Барааны товч тодорхойлолтыг бичих]	[нэгжийн тоо ширхэгийг бичих]	[Хэмжих нэгжийг бичих]	[Бараа хүргэх газрын нэр]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Сервер тоног төхөөрөмж							
1	Хилийн хяналтын нэгдсэн системийн сервер	8	ш	Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар хот	30 хоногт	90 хоногт	
2	Өгөгдлийн сан дундын хадгалах сторэйж сервер	1	ш	Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар хот	30 хоногт	90 хоногт	
3	Хилийн хяналтын нэгдсэн системийн файл хадгалах сервер	4	ш	Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар хот	30 хоногт	90 хоногт	
Сүлжээний свитч							

4	Ракны толгой свич	2	ш	Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар хот	30 хоногт	90 хоногт	
5	КЕМР EB3-LM-X15 Лиценз сунгалт	2	ш	Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар хот	30 хоногт	90 хоногт	

2. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

“ХИЛИЙН ХЯНАЛТ УДИРДЛАГЫН СИСТЕМ” -Д ШААРДЛАГАТАЙ СЕРВЕР ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- | | | |
|-----|--|----|
| 1. | Сервер тоног төхөөрөмж | |
| 1.1 | Хилийн хяналтын нэгдсэн системийн сервер | 8ш |
| 1.2 | Өгөгдлийн сан дундын хадгалах сторэйж сервер | 1ш |
| 1.3 | Хилийн хяналтын нэгдсэн системийн файл хадгалах сервер | 4ш |
| 2. | Сүлжээний свитч | |
| 2.1 | Ракны толгой свич | 2ш |
| 3. | КЕМР EB3-LM-X15 Лиценз сунгалт | 2ш |

№	Барааны нэр	Тоо хэмжээ
1	Хилийн хяналтын нэгдсэн системийн сервер	8
	<p>Required Specification:</p> <p>Зогсуурын 2 Юнит хэмжээтэй Зогсуурын зам байх Баталгаат хугацаа 36 сар</p> <p>Техникийн үзүүлэлт:</p> <ul style="list-style-type: none"> • Chassis Configuration: 2.5" Chassis with up to 24 SAS/SATA Drives, Front PERC 12, 2 CPU • 2x Intel® Xeon® Gold 6548N 2.8G, 32C/64T, 20GT/s, 60M Cache, Turbo, HT (250W) DDR5-5200 • Memory Capacity: 16x 96GB RDIMM ,5600MT/s, Dual Rank • Trusted Platform Module: Trusted Platform Module 2.0 V3 • RAID/Internal Storage Controllers: Front PERC H965i Rear Load (for 2.5" x24 SAS/SATA chassis) • 3 x 1.92TB 10K SAS SSD, RI, up to 24Gbps 512e 2.5in Hot-Plug, AG Drive • Broadcom 57504 Quad Port 10/25GbE, SFP28, OCP NIC 3.0 • Broadcom 57504 Quad Port 10/25GbE SFP28 Adapter, PCIe Full • Broadcom 5720 Dual Port 1GbE LOM • Riser Config 2, 2x8 FH Slots (Gen4), 4x8 FH Slots (Gen5), 2x16 LP Slots (Gen4) • Embedded Systems Management: iDRAC9, Enterprise 16G • RAID/Internal Storage Controllers: Front PERC H965i Rear Load (for 2.5" x24 SAS/SATA chassis) • Dual, Hot-plug, Redundant Power Supply (1+1), 1400W, Mixed Mode • Jumper Cord - C13/C14, 2M, 250V, 10A (EU, TW, APCC countries except ANZ) 	
2	Өгөгдлийн сан дундын хадгалах сторэйж сервер	1
	<p>Зогсуурын 2 Юнит хэмжээтэй Зогсуурын зам байх Баталгаат хугацаа 36 сар</p> <p>Техникийн үзүүлэлт:</p> <ul style="list-style-type: none"> • Bundle: PowerStore Promotion 	

	<ul style="list-style-type: none"> • Memory Capacity: 384GB Appliance DIMM (192GB Per Node) • DRR (Used for Internal Data Tracking): 4:1 • Drives: 16x 7.68TB NVMe SSD • NVRAM Caching Device: PowerStore NVRAM FIPS QTY 2 • Operating Environment: PowerStore Base SW 4 Port Mezz Cards: 25GBE Optical 4 Port Card Pair (SFPs not included) • Optional Appliance IO Module: 10GBASE-T 4 Port IO Module Pair (SFPs not included/not needed) • Optional SFPs: 25GBE Optical SFP Pair • Power Supply: Dual 1800W (200-240V) Lot 9 Power Supply • Kit, includes C20/C19, C20/C13, C14/C13 pairs 	
3	Хилийн хяналтын нэгдсэн системийн файл хадгалах сервер	4
	<p>Зогсуурын 2 Юнит хэмжээтэй Зогсуурын зам эсвэл чихтэй байх Баталгаат хугацаа 36 сар</p> <p>Техникийн үзүүлэлт:</p> <ul style="list-style-type: none"> • Chassis with up to 24 x 2.5" HDDs on BP Fles Bay, 2 x 2.5" 2 CPU Configuration • 2 x Intel Xeon 2.4G, 14C/28T, 9.6GT/s, 35M Cache, Turbo, HT (120W) • DDR4-2400 8 x 32GB RDIMM, 3200MT/s, Dual Rank • 24 x 1.2TB 10K RPM SAS 12Gbps 512e 2.5in Hard Drive • 2 x 800GB SAS SSD 12Gbps 512e 2.5in Flex Bay Hard • 1 x 120GB SSD Internal BOSS Hard Drive • Riser Config 2, 3 x8, 1 x16 slots • PERC H730P RAID Controller, 2GB NV Cache, Mini card • Dual, Hot-plug, Redundant Power Supply (1+1), 750W • Intel X540/I350 2 port 10GbE BASE-T 2 Port 1GbE BASE-T, rNDC 	
4	Ракны толгой свич	2
	<p>Зогсуурын 1 Юнит хэмжээтэй Зогсуурын зам эсвэл чихтэй байх Баталгаат хугацаа 36 сар</p> <p>Порт холболт</p> <p>48 оролт 25GbE SFP28, 4 оролт 100G/QSFP28, 2 оролт 200G/QSF28-DD</p> <p>Системийн хүчин чадал:</p> <p>Performance Throughput - 1.5 Bpps (3.0 Bpps full duplex) Full L2/L3 switching and routing IEEE – 802.1, 802.3 RFC – IP, IPv4, IPv6, OSPF, IS-IS, BGP Multicast, Security, Data Center Bridging Open Networking - Supports 3rd party OS and Access to Linux tools Stacking cable - QSFP28 to QSFP28, Passive Copper Direct Attach Cable, 1 Meter</p>	
5	КЕМР EB3-LM-X15 Лиценз сунгалт	2
	<p>Load master LM-X15-ийн 3 жилийн лицензийн сунгалтад дараах зүйлс орно. Үүнд: Шинэ боломжууд болон програмийн шинэчлэлт, 24/7 хэрэглэгчийн дэмжлэг үйлчилгээ, Тоног төхөөрөмжийг шинэчлэх солиход Edge аюулгүй байдал, Kemp 360</p>	

у дирдлага, програмын мониторинг, Урьдчилан сэргийлэх дохиолол, Кемп 360 Central Centralized программ хангамж Төхөөрөмжийн цуврал дугаар: TSCA42001650, TSCA42001693	
--	--

Тоног төхөөрөмж болон програм хангамж лиценз худалдан авахтай холбоотойгоор авах бүтээгдэхүүний хэрэгцээ тайлбар, үзүүлэлтийн шаардлага зэрэг нэмэлт мэдээлэл

№	Hardware
1	WEB SERVER, APPLICATION SERVER
	<p>Тайлбар:</p> <p>Гаалийн хорио цээрийн Веб, Апп программын хөгжүүлэлт, хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болгох болон гаалийн байгууллагын CAIS программтай интеграци хийгдэж ажиллахад шаардлагатай зохиомол серверүүдийн зохиомж үзүүлэлт, хэмжээ тоо ширхгийг үндэслэн өндөр тооцооллын хүчин чадал бүхий сервер хэрэгтэй гэж үзэн дараах үзүүлэлтийг гаргасан ба тус бодит серверүүдийг гаалийн байгууллагын өөрийн дата төв болон Үндэсний дата төвд тус тус адил тэнцүү байдлаар хуваан байршуулах зорилготой болно. Одоогийн дэд бүтцийн зохион байгуулалтаар манайд шаардлагатай байгаа серверийн 3/3 аар хуваан байршуулахаар тооцоолсон.</p> <p>Мөн цаашид Гаалийн байгууллагын салбарын хэмжээнд нэгдсэн Data Warehouse – Өгөгдлийн нэгдсэн сан зохион байгуулах суурь тухайн системээр эхлэхээр болж байгаа тул цаашдын 5-6 жилийн сервер дэд бүтцийн найдвартай үйл ажиллагааг хангах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа болно.</p>
2	DATABASE SHARED STORAGE
	<p>Тайлбар:</p> <p>Гаалийн хорио цээрийн Веб, Апп программын хөгжүүлэлт, хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болгох болон гаалийн байгууллагын CAIS программтай интеграци хийгдэж ажиллахад шаардлагатай CAIS системийн мэдээллийн санг яг өнөөгийн байдлаар DataFile хадгалах бүхий сервер нь дата хадгалах нийт хэмжээнийхээ 80% хувийн ашиглалттай байгаа ба энэ зөвхөн CAIS системийн ирээдүйн 1-2 жилийн өгөгдөл хадгалах дээд боломжит хязгаар нь юм. Иймээс гарч болох эрсдэлээс хамгаалах юм.</p> <p>Гаалийн хорио цээрийн Веб, Апп программ 100% найдвартай ажиллахад ирээдүйд цаашдын 5-6 жилийн сервер дэд бүтцийн найдвартай үйл ажиллагааг хангах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа болно.</p>
3	File Server
	<p>Тайлбар:</p> <p>Систем өөрийн ажиллах орчиндоо бүх мэдээллийг хадгалах monolithic дэд бүтцээр явах нь эрсдэл өндөр учир storage-н нэмэлтээр оруулж өгөх шаардлагатай. Ингэснээр их хэмжээний мэдээллийг нөөцлөх хадгалах боломж бүрдэнэ.</p> <p>2 ийг авах нь А болон Б байршлуудад тус тусдаа ашиглагдана.</p>
4	TOR SWITCH
	<p>Тайлбар:</p> <p>Уг свитч дээрх өндөр үзүүлэлт бүхий физик серверүүдийг өндөр хурд бүхий 25Gb сүлжээний хурдаар холбогдоход нэн шаардлагатай.</p>
№	Software
5	KEMP EB3-LM-X15 license renewal
	<p>Тайлбар:</p> <p>Бүх серверүүдийн дотоод хөгжүүлсэн болон бүх серверүүдийн нэг хаяг дээрээс гаднаас хэрэглэгч хандахад зориулсан Load balancer дээр зориулагдсан програм хангамжийн лиценз юм. Энэ лиценз нь худалдан авахаар төлөвлөж Load Balancer дээр мөн давхар ашиглагдана.</p>

Үндсэн шаардлага

- Нийлүүлэгч бараа нийлүүлэх хугацаа нь 30-90 хоног байна.

- Суурилуулалтыг гэрээний хугацаанд нийлүүлэгч өөрийн зардлаар хийж, бүрэн ажиллагаанд оруулан, захиалагч талд хүлээлгэх албан бичиг.
- Баталгаат хугацаанд тухайн төхөөрөмжид техникийн эвдрэл, гэмтэл гарвал холбогдох бүх зардлыг хариуцан үнэ төлбөргүй засварлахыг зөвшөөрсөн, баталсан албан бичиг ирүүлнэ.
- Тендерт шалгарсан тохиолдолд нийлүүлэлтийн дараах засвар үйлчилгээг шуурхай үзүүлдэг байна. Өөрийн засварын төвтэй байна. Засварын төвийн үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ эсхүл түрээсийн гэрээний хуулбарыг ирүүлэх, хаяг, байршлын мэдээлэл болон зураг хавсаргана.
- Гаалийн Ерөнхий Газрын дата төвд санал болгож буй тоног төхөөрөмжүүдийг угсарч суурилуулах, тохируулах, эдгээртэй холбоотой зайлшгүй гарч болох нэмэлт тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг санал болгож буй үнийн саналд оруулан тооцсон байна.
- Засвар үйлчилгээний хувьд 3 жилийн баталгаат хугацаанд үйлдвэрлэгч байгууллагын сертификаттай инженерийн тусламжтай 3-дагч байгууллагаар дамжуулахгүй техникийн тусламж үйлчилгээ, зөвлөгөө, тохиргооны дэмжлэгийг үзүүлэх боломжтой бөгөөд холбогдох бичиг баримт илгээнэ.

Нэмэлтээр тавигдах шаардлага

- *Тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгч байгууллагын Монгол дахь албан ёсны борлуулагч, тэдгээртэй холбоотой үйлчилгээг үзүүлэх эрхтэй байна, /Сертификатыг ирүүлэх/*
- *Тухайн тендерт зориулан нийлүүлэх боломжтой тухай үйлдвэрлэгчийн захиа /MAF/ хавсаргах.*
- *Турилагын хувьд 2022, 2023 он тус бүр төсөвт өртгийн 80%-тай дүйцэх сервер, сторэйж, сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлсэн турилагатай байна. Тус бүр гэрээний хуулбар, хүлээлгэж өгсөн тухай акт, гэрээний үүргээ биелүүлсэн тодорхойлолтын хамт ирүүлнэ.*
- *Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд санал болгож буй барааг гэрээний үнэ, хугацаанд багтаан техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлж, хүлээлгэн өгөхийг зөвшөөрсөн, баталсан албан бичиг ирүүлнэ.*
- *Нийлүүлэгч нь нийлүүлж буй тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчээс нь шууд нийлүүлж, нийлүүлсний дараах техникийн тусламжийг гуравдагч байгууллагаар дамжуулахгүйгээр үйлдвэрлэгчээс шууд авч захиалагчид нийлүүлэх баталсан албан бичиг ирүүлнэ.*
- *Нийлүүлэх тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, тохиргоог хийж гүйцэтгэх 2 болон түүнээс дээш мэргэжлийн инженер, техникийн ажилтантай байна. Инженер тус бүрийн сүүлийн 2 жилийн НД тайлан хавсаргаж, сертификатын хуулбарын хамт ирүүлнэ.*
- *Үйлдвэрлэгчийн албан ёсны сургалтад 1 инженер хамруулсан байх ба нотлох баримтыг ирүүлнэ.*

Туршилт, тохируулга, шалгалт

Нийлүүлэгч нийлүүлсэн тоног төхөөрөмжийг суурилуулж, нэг бүрийн ажиллагааг шалган холбогдох тохируулгыг хийнэ. Туршилт тохируулгыг хийхэд ГЕГ-ын мэдээллийн технологийн холбогдох инженерүүд байлцуулан хамтран хийнэ. Туршилт тохируулга хийсэн тухай тэмдэглэл хөтөлж баталгаажуулна.

ГУРАВДУГААР ХЭСЭГ – ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ БА МАЯГТ

ДОЛДУГААР БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Гэрээний ерөнхий нөхцлийг бэлтгэх санамж

ГЕН нь жишиг нөхцөл, заалтыг илэрхийлэх тул түүнд аливаа өөрчлөлтийг оруулж үл болно. ГЕН-д өөрчлөлт оруулах шаардлагатай бол үүнийг ГТН-д тусгана. ГЕН нь гэрээний баримт бичиг мөн учраас гэрээний бүрдэл хэсэг болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

ГАРЧИГ

1. Нэр томъёо
2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах
3. Залилан ба авлигын үйлдэл
4. Захиалгыг өөрчлөх
5. Гэрээнд өөрчлөлт оруулах
6. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах
7. Барааны гарал үүслийн улс
8. Шалгалт туршилт
9. Баглаа боодол
10. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт
11. Зохиогчийн ба оюуны өмчийн эрх
12. Гүйцэтгэлийн баталгаа
13. Даатгал
14. Чанарын баталгаа, баталгаат засвар
15. Төлбөр
16. Үнэ
17. Хуваарийг сунгах
18. Алданги оногдуулах
19. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах
20. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах
21. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах
22. Маргаан шийдвэрлэх
23. Гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал
24. Гэрээний үүргийг шилжүүлэх
25. Гэрээнд ашиглах хэл
26. Татвар ба хураамж
27. Баримтлах хууль
28. Түншлэл
29. Хариуцлагыг хязгаарлах

- Нэр томъёо** 1.1. Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
- (а) “Гэрээ” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд байгуулсан бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ. “Гэрээний баримт бичиг” гэж гэрээнд дурдсан баримт бичиг ба түүнд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хэлнэ.
 - (б) “Гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн ба зохих хэмжээнд гүйцэтгэснээр нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.
 - (в) “Бараа” гэж нийлүүлэгчээс захиалагчид гэрээний дагуу нийлүүлэх тоног төхөөрөмж, машин механизм ба бусад материалыг хэлнэ.
 - (г) “Холбогдох үйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, угсралт, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн үзүүлэх аливаа дагалдах ажил, үйлчилгээ, үүргийг хэлнэ.
 - (д) “Захиалагч” гэж бараа ба холбогдох үйлчилгээг худалдан авч буй, ГТН-д нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
 - (е) “Нийлүүлэгч” гэж гэрээнд заасан бараа, үйлчилгээг нийлүүлж буй этгээдийг хэлнэ.
 - (ж) “Ажлын талбай” гэж ГТН-д тодорхойлсон газрыг хэлнэ.
 - (з) “Хүргэх” гэж нийлүүлэгч барааг гэрээнд заасан нөхцлийн дагуу захиалагчид шилжүүлэн өгөхийг хэлнэ.
 - (и) “Дуусгах” гэж нийлүүлэгч холбогдох үйлчилгээг гэрээнд заасан нөхцлийн дагуу бүрэн гүйцэтгэхийг хэлнэ.
 - (к) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
 - (л) “АХБ” гэж Азийн Хөгжлийн Банкнийг хэлнэ.
 - (м) “Эрх бүхий орнууд” гэж Тавдугаар бүлгийн жагсаалтанд орсон эрх бүхий орнуудыг хэлнэ.
- Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах** 2.1. Нийлүүлэгч нь захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд өгч болохгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.
- 2.2. Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч ГЕН-ийн 2.1-д дурдсан баримт бичиг ба мэдээллийг гэрээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахгүй.

- 2.3. ГЕН-ийн 2.1-д дурдсан гэрээнээс бусад баримт бичиг захиалагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв захиалагч хүсвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц захиалагчид (бүх хувийг) буцааж өгнө.
- 2.4. ГЕН-ийн 2.1, 2.2-т заасан үүргүүд нь дор дурдсан мэдээлэлд хамаарахгүй:
- (а) Захиалагч буюу нийлүүлэгчээс АХБ-д мэдээлэх шаардлагатай мэдээлэл;
 - (б) Аль нэг талын буруутай үйлдлээс үл шалтгаалан одоо нийтэд ил болж байгаа эсхүл хойшид ил болох мэдээлэл;
 - (в) Нийтэд ил болох үед тухайн талын эзэмшилд байсан нь нотлогдох боломжтой болон урьд нь аль нэг өөр талаас шууд буюу шууд бусаар хүлээж авсан мэдээлэл; эсхүл
 - (г) Нууцлалын үүрэг хүлээгээгүй гуравдагч этгээдээс тухайн талд өөр ямар нэгэн байдлаар хууль ёсоор хүртээмжтэй болж байгаа мэдээлэл.

3. Залилан ба авлигын үйлдэл 3.1

АХБ-ны авлигын эсрэг бодлого нь зээлдэгч (түүний дотор АХБ-ны санхүүжилттэй үйл ажиллагааны үр шим хүртэгч) төдийгүй АХБ-ны санхүүжилттэй гэрээний тендерт оролцогч, нийлүүлэгч, гүйцэтгэгчээс худалдан авах ажиллагаа ба гэрээний хэрэгжилтийн явцад ёс зүйн өндөр хэм хэмжээг баримтлахыг шаарддаг. Энэ бодлогыг мөрдлөг болгох үүднээс АХБ нь:

(а) Энэхүү заалтын хүрээнд доор дурдсан нэр томъёог дараах байдлаар тодорхойлно:

(1) “авлигын үйлдэл” гэдэг нь бусдын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд ямар нэг үнэ цэнэтэй зүйлийг шууд буюу шууд бусаар санал болгох, өгөх, авах, эсхүл хүсэхийг;

(2) “залилан мэхлэх үйлдэл” гэдэг нь санхүүгийн болон бусад үр шим хүртэх эсхүл үүрэг хариуцлагаас мултрах зорилгоор бусдыг санаатайгаар буюу санамсаргүйгээр төөрөгдүүлэх, эсхүл төөрөгдүүлэхийг оролдсон аливаа үйлдэл хийх, баримтыг орхигдуулах, худал мэдүүлэхийг;

(3) “дарамт шахалт үзүүлэх үйлдэл” гэдэг нь бусдын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд бусдад буюу түүний өмч хөрөнгөнд шууд эсхүл шууд бусаар хохирол учруулах, эсхүл хохирол учруулахаар заналхийлэхийг;

(4) “үгсэн хуйвалдах үйлдэл” гэдэг нь хоёр буюу түүнээс дээш тал зүй бус зорилгод хүрэх, түүний дотор бусдын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх зорилгоор хоорондоо тохиролцоо хийхийг;

(5) “шударга бус байдлын зөрчил” гэдэг нь АХБ-ны Шударга байдлын зарчим ба журамд тодорхойлсноор, авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, үгсэн хуйвалдах, албан тушаалаа урвуулан ашиглах болон ийм үйлдлийг таслан зогсоход саад учруулах байдлаар АХБ-ны Авлигын эсрэг бодлогыг зөрчихийг;

(б) “саад учруулах үйлдэл” гэдэг нь (а) АХБ-наас хийж буй хяналт шалгалтын явцад нотолгоо болох баримт материалыг санаатайгаар устгах, хуурамч баримт үйлдэх, баримт материалыг өөрчлөх буюу нуун дарагдуулах; (б) АХБ-ны хяналт шалгалтын явцад саад учруулахын тулд хяналт шалгалт хийж буй хүмүүст худал мэдүүлэг өгөх; (в) АХБ-ны Авлигатай тэмцэх, Шударга байдлын газраас хийж буй хяналт шалгалттай холбогдуулан гаргаж өгөхийг хүссэн мэдээлэл, баримт бичиг, данс бүртгэлийг гаргаж өгөхгүй байх; (г) хяналт шалгалттай холбоотой асуудлаар мэдүүлэг өгүүлэхгүй байх эсхүл мэдүүлэг өгөхөд нь саад учруулахын тулд аливаа этгээдэд заналхийлэх, дарамт шахалт үзүүлэх, түүнийг айлган сүрдүүлэх; (д) АХБ-тай байгуулсан гэрээний дагуу аудит хийх буюу мэдээлэл олж авахад санаатайгаар саад учруулахыг тус тус хэлнэ.

(б) Гэрээний эрх олгохоор санал болгосон тендерт оролцогч нь гэрээний эрхийн төлөө өрсөлдөх явцдаа шууд өөрөө эсхүл төлөөлөгчөөрөө дамжуулан авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, үгсэн хуйвалдах, саад учруулах эсхүл шударга бус байдлын бусад зөрчил гаргасан болох нь тогтоогдвол гэрээний эрх олгох саналаас татгалзана;

(в) АХБ-наас санхүүжилт авсан зээлдэгчийн эсхүл АХБ-ны санхүүжилтээс үр шим хүртэгчийн төлөөлөгч нь худалдан авах ажиллагаа, эсхүл гэрээ хэрэгжүүлэх явцад авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, үгсэн хуйвалдах, саад учруулах эсхүл шударга бус байдлын бусад зөрчил гаргахад оролцсон, мөн зээлдэгч энэ байдлыг засаж залруулах талаар АХБ-ны шаардлагад нийцэхүйц зохистой арга хэмжээг цаг тухайд нь аваагүй болох нь хэзээ нэгэн цагт тогтоогдвол тухайн гэрээнд хуваарилсан санхүүжилтийн хэсгийг цуцална;

(г) Хэрэв компани ба хувь хүн шууд өөрөө эсхүл төлөөлөгчөөр дамжуулан авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, үгсэн хуйвалдах, саад учруулах эсхүл шударга бус байдлын бусад зөрчил гаргахад оролцсон болох нь тогтоогдвол, тодорхой буюу тодорхой бус хугацаагаар АХБ-наас санхүүжүүлсэн, зохион байгуулсан эсхүл дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагаанд оролцох, эсхүл АХБ-наас санхүүжүүлсэн, хэрэгжүүлсэн эсхүл дэмжлэг үзүүлсэн гэрээнээс санхүүгийн болон бусад хэлбэрээр үр шим хүртэх эрхгүй болохыг зарлах гэх мэтээр АХБ-ны Авлигын эсрэг бодлого, Шударга байдлын зарчим ба журам (тухай бүрдээ шинэчлэгдэж байдаг)-ын дагуу компани, хувь хүнд хориг тавина;

3.2 Тендерт оролцогч, нийлүүлэгч, гүйцэтгэгчийн данс бүртгэл болон тендерийн санал ирүүлэх, гэрээний гүйцэтгэлтэй холбоотой баримт бичгийг хянан шалгах, АХБ-наас томилсон аудитын байгууллагаар тэдгээрийг хянуулахыг АХБ, түүний төлөөлөгчид зөвшөөрөхийг тендерт оролцогч, нийлүүлэгч, гүйцэтгэгчээс хүссэн заалтыг АХБ-ны санхүүжилттэй тендерийн баримт бичиг болон гэрээнд тусгасан байхыг шаардах эрхтэй.

**Захиалгыг
өөрчлөх**

4.1. Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний ерөнхий цар хүрээнд багтаан доор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгыг хэдийд ч өөрчлөх эрхтэй. Үүнд:

- (а) гэрээний дагуу нийлүүлэгдэх барааг захиалагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар зураг, зураг төсөл, техникийн тодорхойлолтыг өөрчлөх;
 - (б) тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр;
 - (в) барааг хүргэх газар.
- 4.2. Нийлүүлэгч нь захиалгын өөрчлөлтийн (цаашид “өөрчлөлт” гэх) улмаас гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацаанд үзүүлэх нөлөөг (хэрэв нөлөөлөх бол) харгалзан түүний зардлын нарийвчилсан тооцоо, хэрэгжүүлэх хуваарийг гаргаж, өөрчлөлтийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш арван (10) хоногийн дотор захиалагчид танилцуулна.
- 4.3. Хэрэв захиалгыг өөрчилсний улмаас гэрээний аль нэгэн заалтыг нийлүүлэгчээс биелүүлэхэд үнийн хувьд өссөн буюу багассан эсхүл цаг хугацааны хувьд нэмэгдсэн буюу багассан тохиолдолд гэрээний үнэ эсхүл хүргэх ба дуусгах хуваарьт эсхүл аль алинд нь тохиргоо хийж, гэрээнд зохих ёсоор нэмэлт өөрчлөлт оруулна. Нийлүүлэгч нь захиалгыг өөрчлөх мэдэгдлийг захиалагчаас хүлээн авснаас хойш 24 цагийн дотор энэ заалтын дагуу тохиргоо хийлгэх шаардлагаа мэдэгдэнэ.
- 4.4. Захиалагч ГЕН-ийн 4.2-т дурдсан нийлүүлэгчийн тооцоог үндэслэж өөрчлөлтийг бичгээр батлах ба ийнхүү баталгаажуулах хүртэл нийлүүлэгч ГЕН-ийн 4.1-д дурдсан өөрчлөлтийг гүйцэтгэхгүй.
- 4.5. Харилцан тохиролцсон өөрчлөлт нь гэрээний хэсэг болох ба энэ өөрчлөлтөд гэрээний нөхцөл үйлчилнэ.
- Гэрээнд өөрчлөлт оруулах** 5.1. Энэхүү гэрээний 4 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд гэрээний нөхцлийг засварлах, эсхүл өөрчилж болохгүй. Зайлшгүй шаардлагатай өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.
- Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах** 6.1. Захиалагч урьдчилж бичгээр зөвшөөрөөгүй тохиолдолд нийлүүлэгч гэрээ, түүний аль нэг хэсгийг туслан гүйцэтгүүлэх зорилгоор туслан гүйцэтгэгчийг сонгож түүнтэй гэрээ байгуулж болохгүй.
- 6.2. Гэрээг хэрэгжүүлэх туслан гүйцэтгэгч хариуцсан ажил үүрэгт ногдох гэрээний холбогдох нөхцлийг бүрэн биелүүлэхийг нийлүүлэгч батламжлана.
- Барааны гарал үүслийн улс** 7.1. Нийлүүлэгч, түүний туслан гүйцэтгэгч нь АХБ-ны эрх бүхий гишүүн орны харьяат байна. Нийлүүлэгч, түүний туслан гүйцэтгэгч нь тухайн орны иргэн, эсхүл тус улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулдаг бол тухайн улсын харьяат гэж үзнэ.
- 7.2. АХБ-наас санхүүжиж буй төслийн худалдан авах ажиллагааны хувьд гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа ба холбогдох үйлчилгээ нь эрх бүхий улсаас гарал үүсэлтэй байна. “Барааны гарал үүслийн улс” гэдэгт тухайн барааг ургуулсан, олборлосон, бойжуулсан, хийж бүтээсэн, үйлдвэрлэсэн, эсхүл боловсруулсан улс орон буюу газар нутгийг хэлнэ. Хийж бүтээсэн гэдэг нь үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, уг эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

Шалгалт туршилт	8.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. ГТН-д эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгчийг нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.
	8.2.	Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар, барааг хүргэх газар болон эцсийн цэгт явуулж болно. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар явуулсан тохиолдолд захиалагчийг шаардлагатай байгууламж, зураг, үйлдвэрлэлийн өгөгдөл болон бусад туслалцаагаар үнэ төлбөргүй хангана.
	8.3.	Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй бол захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсхүл техникийн тодорхойлолтод нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.
	8.4.	Барааг тээвэрлэхээс өмнө захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол улсад орж ирсний дараа түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох захиалагчийн эрхийг хөндөхгүй.
	8.5.	Энэ зүйлийн аль ч нөхцөл нийлүүлэгчийг гэрээний баталгаат засварын болон бусад үүргээс чөлөөлөхгүй.
Баглаа боодол	9.1.	Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэхийн тулд гэрээнд заасны дагуу баглаж бооно. Баглаа боодол нь тээвэрлэлтийн хатуу нөхцөл, тээвэрлэлт ба ил хадгалалтын халуун, хүйтэн болон давс, хур тунадас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрт ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзсан байна.
	9.2.	Баглаа боодол, түүний дотор ба гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ гэрээнд, нэн ялангуяа ГТН-д заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.
Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	10.1.	Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн хувилбарыг хэрэглэнэ. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
	10.2.	Гэрээнд хэрэглэсэн CIP, EXW, FOB, FCA, CIF болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.

Зохиогчийн ба оюуны өмчийн эрх	11.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглах явцад патент, барааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг зөрчсөн тухай гуравдагч этгээдийн гомдлыг нийлүүлэгч захиалагчид барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна. нийлүүлэгчээс захиалагчид ирүүлсэн аливаа зураг төсөл, баримт бичиг болон мэдээ, мэдээлэл агуулсан бусад материалын зохиогчийн эрх нь нийлүүлэгчид хадгалагдана. Хэрэв тэдгээрийг гуравдагч этгээдээс, тухайлбал материалын нийлүүлэгчээс шууд эсхүл нийлүүлэгчээр дамжуулан захиалагчид ирүүлсэн бол тэдгээр материалын зохиогчийн эрх нь уг гуравдагч этгээдэд хадгалагдана.
Гүйцэтгэлийн баталгаа	12.1.	Нийлүүлэгч ГТН-д заасан мөнгөн дүн бүхий гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор захиалагчид өгнө.
	12.2.	Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж чадаагүйгээс захиалагчид учрах хохирлыг нөхөж барагдуулахад уг баталгаа зориулагдана. Гэрээний гүйцэтгэлийг ГЕН-ийн 17.2-ын дагуу сунгахад нийлүүлэгч мөн хугацаагаар гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй хугацааг сунгана.
	12.3.	Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний валютаар, банкны баталгааны маягтын хэлбэрээр гаргасан баталгаа байна.
	12.4.	ГТН-д шаардсан бол чанарын баталгааны хугацааг оруулан, нийлүүлэгч гэрээний дагуу ажлыг дуусгасан өдрөөс хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно.
Даатгал	13.1.	ГТН-д тусгайлан өөрөөр заагаагүй бол барааг үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах болон хүргэх үед гарч болох хэвийн алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалж бүх барааг Инкотермсийн зохих нөхцлийн дагуу эсхүл ГТН-д заасан хэлбэрээр төгрөгөөр даатгуулна.
Чанарын баталгаа, баталгаат засвар	14.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, гэмтэл согоггүй бөгөөд хамгийн сүүлийн буюу өнөөгийн загварын, техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна. Өөрийн болон туслан гүйцэтгэгчийн бараа нийлүүлэхэд ашиглах бүх материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл зэрэг нь шинэ, сайн чанарын болон зориулалтынх байна гэдгийг нийлүүлэгч баталгаажуулна.
	14.2.	ГТН-д өөрөөр заагаагүй бол баталгаат засвар нь барааг хүргэж, ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сар, эсхүл барааны гарал үүслийн улсын боомтоос ачсан өдрөөс хойш 18 сар гэсэн хугацааны аль эрт дуусах хугацаанд хүчинтэй байна.
	14.3.	Захиалагч энэхүү баталгаатай холбогдох гомдлыг нийлүүлэгчид бичгээр шуурхай мэдэгдэнэ.
	14.4.	Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой бараа, эсхүл түүний эд ангийг үнэ төлбөргүй, шуурхай засварлах буюу солино.

- 14.5. Захиалагч нь ГЕН-ийн 14.2-т заасныг үл харгалзан, ГЕН-ийн 14.4-т заасны дагуу гэмтэл согогийг арилгаснаас хойш 12 сарын дотор засварласан бараанд энэ төрлийн гэмтэл согог дахин гарсан тухай бичгээр мэдэгдэл ирвэл уг гэмтэл согогийг үнэ төлбөргүй шуурхай арилгана.
- 14.6. Хэрэв нийлүүлэгч гэмтэл согог гарсан мэдэгдэл хүлээн аваад гэрээний дагуу түүнийг арилгахгүй бол захиалагч өөрөө нийлүүлэгчийн зардлаар уг гэмтэл согогийг арилгах эрхтэй. Энэ зүйлд заасны дагуу нийлүүлэгчийн гаргах баталгаа нь гэрээнд заасан захиалагчийн бусад эрх, үйл ажиллагааг хязгаарлахгүй.
- Төлбөр**
- 15.1. Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг ГТН-д дурдана.
- 15.2. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараа төлбөр хийхийг хүссэн хүсэлтийг төлбөрийн нэхэмжлэх болон ГЕН-ийн 10 дугаар зүйлд заасан баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ.
- 15.3. ГТН-д өөрөөр заагаагүй бол захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ.
- 15.4. Гэрээний дагуу нийлүүлэгчид хийх төлбөрийн мөнгөн тэмдэгт нь Монгол төгрөг байна.
- Үнэ**
- 16.1. Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон үнийг баримтлана. ГТН-ийн үнэ тохируулах нөхцлийн дагуу үнийг тохируулах, эсхүл ГЕН-ийн 4 дүгээр зүйлийн дагуу захиалгыг өөрчлөхөд тендерт санал болгосон үнэ өөрчлөгдвөл, өөрчлөгдсөн үнийг баримтлана.
- Хуваарийг сунгах**
- 17.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
- 17.2. Нийлүүлэгч дараах тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарийг сунгах тухай хүсэлт гаргаж болно. Үүнд:
- (а) захиалагч ГЕН-ийн 4 дүгээр зүйлд заасны дагуу захиалгыг өөрчилсөн;
 - (б) захиалагчаас гаргаж өгөх материал, зураг, эсхүл үйлчилгээ хугацаа хоцорсон (үйлчилгээ гэдэгт гэрээний дагуу захиалагчийн гаргах зөвшөөрөл, баталгаа орно);
 - (в) ГЕН-ийн 23 дугаар зүйлд заасан гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал үүсвэл;
 - (г) захиалагчийн өгсөн захиалгаас шалтгаалан ажлын гүйцэтгэл хойшилсон.
- Нийлүүлэгч хугацаа хоцрохоос урьдчилан сэргийлэхийн тулд бололцоотой бүхнийг хийсэн гэдгийг захиалагчид нотлон харуулах үүрэгтэй. Хугацаа хоцролтын шалтгааныг арилгах, даван туулах арга замуудыг талууд хэлэлцэнэ.

	17.3.	Нийлүүлэгч ГЕН-ийн 17.2-т заасан нөхцөл байдал бий болсны улмаас бараа нийлүүлэлтийн хуваарь ямар нэг байдлаар хоцорч болохыг захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдээгүй, эдгээр нөхцөл байдал бий болсныг нотлон харуулаагүй тохиолдолд ГЕН-ийн 17.2-ыг үл харгалзах ба хуваарийг сунгахгүй.
Алданги ногдуулах	18.1.	ГЕН-ийн 23 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд захиалагч нийлүүлэгчээс хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги ногдуулж, гэрээний үнийг уг хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд захиалагч ГЕН-ийн 19 дүгээр зүйлийн дагуу гэрээг цуцлах тухай асуудлыг хөндөж болно.
Үүргээ биелүүлээгүй- гээс гэрээг цуцлах	19.1.	Захиалагч доор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад арга хэрэгслийг ашиглалгүйгээр нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Үүнд: <ul style="list-style-type: none"> (а) Нийлүүлэгч гэрээнд заасан эсхүл ГЕН-ийн 17 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд аль нэг болон бүх барааг хүргэж чадаагүй; (б) Нийлүүлэгчийн ирүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаарлага хангаагүй бөгөөд гэрээний бусад үүргээ биелүүлээгүй; (в) Нийлүүлэгч ГЕН-ийн 19.1.(а), 19.1.(б)-д заасан нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг захиалагчаас хүлээн аваад 10 хоногийн дотор (захиалагч үүнээс урт хугацаа заах эрхтэй) алдаагаа залруулаагүй; (г) Нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авлига, залилан мэхлэх, үгсэн хуйвалдах болон айлган сүрдүүлэх үйлдэлд холбогдсоныг шүүх, эсхүл эрх бүхий байгууллага тогтоосон бол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцлана.
	19.2.	ГЕН-ийн 19.1-ийн дагуу гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцалсан тохиолдолд захиалагч нийлүүлэгдээгүй барааг тохиромжтой гэж үзсэн нөхцөлөөр худалдан авах эрхтэй ба үүнтэй холбогдон гарсан нэмэлт зардлыг нийлүүлэгч хариуцна. Энэ зүйлийг үл харгалзан нийлүүлэгч гэрээний цуцлагдаагүй хэсгийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.
Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах	20.1.	Нийлүүлэгч дампуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Ингэхдээ захиалагч нийлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөхгүй. Гэвч ийнхүү цуцалсан нь захиалагчид үүссэн эсхүл ирээдүйд үүсэх аливаа эрхийг хөндөхгүй.
Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах	21.1.	Захиалагч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдэж гэрээг хэдийд ч бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. ³ Захиалагч мэдэгдэлдээ өөрийн шаардлагаар гэрээг цуцлах болсон үндэслэл болон гэрээний аль хэсгийг, хэзээнээс цуцалж буйг заавал дурдана.

³ Захиалагч гэрээг цуцлах шийдвэрийг холбогдох дээд шатны байгууллагын болон АХБ-ны зөвшөөрөлтэйгээр зөвхөн зайлшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гаргана.

	21.2.	Мэдэгдэл нийлүүлэгчид очсоноос хойш 30 хоногийн дотор тээвэрлэхэд бэлэн болсон барааг захиалагч гэрээнд заасан үнэ болон бусад нөхцлөөр худалдаж авна. Үлдэх барааны хувьд захиалагч доор дурдсан сонголтын аль нэгийг, эсхүл хоёуланг хэрэгжүүлнэ. Үүнд: (а) үлдэх барааны одоогоор бэлэн болсон аливаа хэсгийг гэрээнд заасан үнэ, бусад нөхцлөөр авах, болон/эсхүл (б) үлдэх барааг цуцлах ба нийлүүлэгчийн хагас бэлэн болсон бараа, гэрээг хэрэгжүүлэх зорилгоор худалдаж авсан материал, эд ангийн хэлэлцэж тохирсон үнийг төлнө. Энэ дүнд захиргааны зардлын болон ашгийн зохих хэмжээг оруулж тооцно.
Маргаан шийдвэрлэх	22.1.	Захиалагч ба нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбогдон гарч болох маргааныг зөвшилцөл болон албан бус хэлэлцээрээр шийдэхийг хичээнэ.
	22.2.	Хэрэв хэлэлцээр 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг шийдэж чадахгүй тохиолдолд ГТН-д өөрөөр заагаагүй бол талууд шүүхэд хандах эрхтэй.
Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал	23.1.	Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол ГЕН-ийн 17 дугаар зүйлийн дагуу түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.
	23.2.	Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
Гэрээний үүргийг шилжүүлэх	24.1.	Нийлүүлэгч ямар ч тохиолдолд захиалагчтай бичгээр урьдчилан зөвшилцөөгүй бол гэрээний үүргийг бүхлээр нь болон хэсэгчлэн гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
Гэрээнд ашиглах хэл	25.1.	Гэрээ болон нийлүүлэгч, захиалагчийн хооронд солилцож байсан гэрээнд хамааралтай бүх албан захидал, баримт бичгийг ГТН-д заасан хэл дээр үйлдэнэ. Гэрээний бүрдэл хэсэг болох дагалдах баримт бичиг болон хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох боловч тэдгээрийн холбогдох хэсгийн үнэн зөв орчуулгыг ГТН-д заасан хэл дээр үйлдэн хавсаргана. Энэ тохиолдолд хэрэв гэрээг тайлбарлах шаардлага гарвал уг орчуулгыг баримтална.
	25.2.	ГЕН-ийн 25.1-д заасан хэл рүү орчуулах зардал болон орчуулгын үнэн зөвийг нийлүүлэгч хариуцна.
Татвар ба хураамж Баримтлах хууль	26.1.	Монгол улсын нутаг дэвсгэрийн гадна ногдуулдаг бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.
	27.1.	ГТН-д өөрөөр зааснаас бусад тохиолдолд, гэрээнд захиалагчийн улсын хуулийг баримталж, түүний дагуу тайлбарлана.

- Түншлэл** 28.1. ГТН-д өөрөөр зааснаас бусад тохиолдолд хэрэв нийлүүлэгч нь түншлэл бол холбогдох бүх талууд гэрээний заалтыг хэрэгжүүлэхдээ захиалагчийн өмнө хамтаар болон дангаар хариуцлага хүлээх бөгөөд түншлэлд хариуцлага хүлээлгэх үүднээс нэг талыг ахлагчаар томилно. Түншлэлийн бүтэц бүрэлдэхүүнд захиалагчаас урьдчилан өгсөн зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулж болохгүй.
- Хариуцлагыг хязгаарлах** 29.1. Илтэд хайхрамжгүй хандах эсхүл санаатайгаар зүй бусаар авирласнаас бусад тохиолдолд:
- (а) Аль ч тал нөгөө талдаа учирсан аливаа шууд бус эсхүл шалтгаан бүхий алдагдал, хохирол, түүнчлэн ашиглалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ашиг орлогын хувьд хүлээсэн алдагдал, эсхүл хүүгийн зардал зэргийг хариуцахгүй. Гэхдээ энэхүү үл хамаарах нөхцөл нь захиалагчид алданги төлөх нийлүүлэгчийн аливаа үүрэгт хамаарахгүй;
- (б) Энэхүү гэрээний дагуу нийлүүлэгчээс захиалагчид учруулсан гэмтэл хохирол эсхүл өөр бусад үндэслэлээр хүлээх хариуцлагын нийт хэмжээ нь ГТН-д заасан дүнгээс хэтрэхгүй. Гэхдээ энэхүү хязгаарлалт нь доголдолтой тоног төхөөрөмжийг засварлах буюу солихтой холбогдон гарсан зардал эсхүл патентын зөрчил гаргасны улмаас захиалагчид учруулсан хохирлыг барагдуулах нийлүүлэгчийн аливаа үүрэгт хамаарахгүй.

НАЙМДУГААР БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Гэрээний тусгай нөхцлийг бэлтгэх санамж

ГЕН-д дурдсан захиалагч, бараа зэрэг нэр томъёо тухайн гэрээнд юуг илэрхийлэхийг ГТН-д заадаг. ГТН-ийг бэлтгэхдээ дараах зүйлсийг шалгана. Үүнд:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд ГТН-ийг ишилсэн бол холбогдох нөхцлийг ГТН-д заавал оруулна.
2. Тухайн гэрээний шаардлагаар ГЕН-ийг засварлах, илүү дэлгэрүүлэх тохиолдолд эдгээрийг ГЕН-д бус, ГТН-д тусгана.
3. ГЕН ба ГТН хоорондоо зөрчилдсөн тохиолдолд ГТН-ийг баримтална.
4. ГТН-ийг хэрхэн бэлтгэх тухай зааврыг [] дөрвөлжин хаалтанд бичив. Зарим жишээ нөхцлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч боловсруулна.

НАЙМДУГААР БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 1.1.(д)	Захиалагч: <i>Сангийн яам</i>
ГЕН 1.1 (ж)	Ажлын талбай: <i>Гаалийн ерөнхий газар, Их тойруу 81/1 Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14193 Монгол Улс</i>
ГЕН 8.1	“Нийлүүлэлтийн хуваарь” буюу Зургаадугаар бүлэгт заасан туршилт болон шалгалтыг дараах байдлаар явуулна: <i>Төхөөрөмжийг хүлээн авахын өмнө нийлүүлж буй тоног төхөөрөмж нь техникийн шаардлагыг хангаж буй эсэхийг баталгаажуулж туршилт, шалгалтыг хариуцан туршилт хийх эрх бүхий төлөөлөгчийг томилсон байна. Туршилт шалгалт хийх хугацаа 30 хоног байна.</i>
ГЕН 9.2	Баглаа боодлын гадна ба дотор талд дараах мэдээллийг зааж өгнө: <ul style="list-style-type: none"> - <i>Захиалагчийн нэр</i> - <i>Гэрээний дугаар</i> - <i>Үйлдвэрлэгдсэн улс</i> - <i>Хүлээж авах хаяг</i> - <i>Цэвэр жин</i> - <i>Нийт жин</i> - <i>Баглааны хэмжээ</i> - <i>Баглааны дугаар</i> - <i>Нийлүүлэгчийн нэр</i> - <i>Харьцах заавар.</i>
ГЕН 10.1	Нийлүүлэгч дараах баримтыг бүрдүүлж өгнө. Үүнд: <p><u>А. “Монгол улсын гаднаас санал болгосон бараа (CIP):</u></p> <p>Нийлүүлэгч барааг тээврийн хэрэгсэлд ачсаны дараа энэ тухай бүрэн мэдээллийг захиалагч болон даатгалын байгууллагад бичгээр мэдэгдэнэ. Мэдэгдэлд гэрээний дугаар, барааны нэр, тоо ширхэг, тээврийн хэрэгслийн нэр, тээврийн баримтын дугаар, ачсан боомт, боомтоос гарах огноо, буулгах боомт зэргийг дурдана. Нийлүүлэгч дараах баримт бичгийг⁴ захиалагч ба даатгалын байгууллагад шуудангаар илгээнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь; 2) барааг бүрэн бүтэн усан онгоцонд ачуулсан болохыг гэрчлэх “Тээврийн хөлс урьдчилан төлөгдсөн” гэсэн тэмдэглэл бүхий, бусдад шилжүүлж болох ачааны нэхэмжлэхийн үндсэн болон 3 ширхэг хуулбар хувийг бусдад үл шилжүүлэх ачааны нэхэмжлэхийн 3 ширхэг хуулбар хувийн хамт; 3) барааны багц бүрийн баглаа боодлын жагсаалт; 4) даатгалын гэрчилгээ; 5) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ; 6) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалт, туршилтын гэрчилгээ; 7) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан бичиг баримтыг барааг хүргэх газар, эсхүл боомтод ирэхээс 7 хоногийн өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч өөрөө хариуцна.”</p> <p><u>Б. “Монгол улсын дотроос санал болгосон бараа (EXW):</u></p>

⁴ Инкотермс-ийн аль нөхцлийг ашиглахаас үүдэн бусад зохих баримт бичгийн нэрийг жагсаана.

	<p>1) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</p> <p>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</p> <p>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</p> <p>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</p> <p>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</p> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс 7 хоногийн өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч өөрөө хариуцна.”</p>
ГЕН 12.1	Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний үнийн 10 хувьтай тэнцэх дүнтэй байна.
ГЕН 12.4	Захиалагч барааг албан ёсоор хүлээн авч дууссаны дараа ГЕН-ийн 14.2 дугаар зүйлд заасны дагуу нийлүүлэгчийн үүргийг хангах зорилгоор гүйцэтгэлийн баталгааг гэрээний үнийн 5 хувь хүртэл бууруулна.
ГЕН 13.1	<p>Даатгалын шаардлага:</p> <p>Нийлүүлэгч нь ГЕН-ийн 13.1 дүгээр зүйлийн дагуу барааг барааны СІР эсвэл EXW үнийн 110 хувьтай тэнцэх хэмжээгээр даатгасан байвал зохино. Энэ нь дайны эрсдэл ба бослого үймээн зэрэг “бүх эрсдэл”-ийг хамарсан, агуулахаас агуулах хүртэл нөхцөлтэй байна.</p>
ГЕН 14.2	Баталгаат засварын хүчинтэй хугацаа: 3 жил
ГЕН 15.1	<p>Гэрээний үнийн төлбөрийг дараах байдлаар хийнэ. Үүнд:</p> <p>Захиалагч Монгол улсын гаднаас санал болгосон барааны төлбөрийг нийлүүлэгчид дараах нөхцлийн дагуу хийнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1. <u>Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:</u> Барааны гэрээний үнийн 50 хувьтай тэнцэх дүнг бараа ачигдсаны дараа ГЕН-ийн 10.1 дүгээр зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. 2. <u>Барааг хүлээн авч дууссаны /сууриллуулсны/ дараа төлөх төлбөр:</u> Гэрээний үнийн 50 хувьтай тэнцэх дүнг бараа хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх ба захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө. <p>Захиалагч Монгол улсын дотроос санал болгосон барааны төлбөрийг дараах нөхцлийн дагуу хийнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1. <u>Гүйцэтгэлийн төлбөр:</u> Гэрээний үнийн 50 хувьтай тэнцэх дүнг бараа ирсэний дараа ГЕН-ийн 10.1 дүгээр зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. 2. <u>Барааг хүлээн авч дууссаны дараа төлөх төлбөр:</u> Гэрээний үнийн 50 хувьтай тэнцэх дүнг бараа ирснээс хойш 50 хоногийн дотор нэхэмжлэх ба хүлээн авсан тухай захиалагчийн актыг үндэслэн төлнө.
ГЕН 16.1	<i>Хамаарахгүй</i>
ГЕН 18.1	<p>Алдангийн хувь: 7 хоног тутамд гэрээний үнийн 0.5 хувь</p> <p>Алдангийн дээд хэмжээ: гэрээний үнийн 10 хувь</p>
ГЕН 22.2	<p>Маргаан шийдвэрлэх байгууллага:</p> <p>Маргааныг шийдвэрлэхдээ Монгол Улсын хуулийн дагуу явуулна.</p> <p>Маргааныг шийдвэрлэх газар нь Улаанбаатар хот байна.</p>
ГЕН 25.1	Гэрээний хэл нь Монгол хэл байна.
ГЕН 27.1	Аль улсын хуулийг баримтлах: Монгол улс
ГЕН 28.1	Түншлэлийн гишүүн нь хамтаар болон дангаар хариуцлага хүлээх “шаардлагатай”

ГЕН 29.1	Хариуцлагын нийт хэмжээ: Гэрээний үнийн 100 хувь
----------	--

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

АГУУЛГА

1. Гэрээний маягт
2. Гүйцэтгэлийн баталгаа (банкны батлан даалт)
3. Урьдчилгаа төлбөрийн баталгаа (банкны батлан даалт)

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

Гэрээний нэр:

Гэрээний дугаар:

..... ХОТ

Нэг талаас, [захиалагчийн нэрийг оруулах] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэрийг оруулах] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож, оны дугаар сарын-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. АХБ-ны санхүүжилттэй төслийн хүрээнд АХБ-ны Худалдан авах ажиллагааны журам болон Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу бараа нийлүүлэхтэй холбогдон захиалагч ба нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний үнийг тоогоор ба үсгээр оруулах] төгрөг бүхий гэрээний үнэтэй (цаашид “гэрээний үнэ” гэх) энэхүү гэрээний дагуу нэр төрлийн барааг (цаашид “бараа” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Нийлүүлэгч нь дээр дурдсан нэр төрлийн барааг оны дугаар сарын-ны өдрийн дотор нийлүүлэн хүлээлгэж өгнө.
4. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг (цаашид “гэрээний баримт бичиг” гэх) болно. Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Тендер ирүүлэх маягт ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Нийлүүлэх хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.
Бусад шаардлагатай баримт бичиг⁵;

5. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөлд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

⁵ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

6. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
7. Гэрээнд холбогдох аливаа асуудлаар талууд бичгээр харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГАА (БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

[Гэрээний нэр ба дугаарыг оруулах]

Хэнд: [захиалагчийн нэрийг оруулах]

..... [нийлүүлэгчийн нэрийг оруулах] (цаашид “нийлүүлэгч” гэх) нь тоот гэрээний (цаашид “гэрээ” гэх) хүрээнд [барааны нэрийг оруулах] барааг нийлүүлэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Нийлүүлэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, [захиалагчийн нэрийг оруулах] (цаашид “захиалагч” гэх)-ийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан доор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

..... [банкны нэрийг оруулах] (цаашид “Банк” гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь баталгаа гаргагчийн хувьд нийлүүлэгчийн нэрийн өмнөөс [баталгааны үнийн дүнг тоо ба үсгээр оруулах] төгрөгөөс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг захиалагчийн өмнө хариуцаж, нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруйд, үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээнэ гэдгийг үүгээр баталгаажуулж байна. Ингэхдээ дээр дурдсан баталгааны үнийн дүнгийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнд ямарваа нэгэн нотлох үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч ба нийлүүлэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл, эсхүл түүний дагуу нийлүүлэх бараа, эсхүл гэрээний баримт бичигт оруулж болох аливаа нэмэлт өөрчлөлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх нэмэлт өөрчлөлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь барааг хүлээн авч дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш /огноог оруулах/ хугацаанд хүчинтэй байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг: